

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөн хамгаалах холбооноос эрхлэн гаргав



Бөхөнгийн экологи болон хамгааллын асуудлаар мэдээлэл солилцох зургаан хэл дээр гардаг хэвлэл



“Бөхөнгийн сүрлэг ооно” Астрахан мужийн Степной байгалийн нөөц газар. Гэрэл зургийг: Валерий Малеев

Хэвлэлийг ивээн тэтгэсэн:



Агуулга

Дугаарын онцлох сэдэв

Энхтүвшингийн Шийлэгдамба, Антон Мезнев. Бөхөнгийн олон улсын худалдааны талаарх асуудлыг Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенц (CITES)-ийн Талуудын шийдвэрт тусгах нь эерэг алхам мөн үү?

Шинэ мэдээ

Буянаагийн Чимэддорж. Монгол бөхөн хамгаалах хамтын менежментийн зөвлөл байгуулахаар боллоо

Александра Букварева болон түүний баг. 2019 оны “Бөхөнгийн өдөр”

Буянаагийн Чимэддорж. “3800 Монгол бөхөнгийн төлөө хамтдаа гүйлээ”

Бабетта Фюрер. “Степной тандалт судалгаа” төсөл хэрэгжиж эхэллээ!

Хэвлэлийн мэдээ

Казакстан дахь бөхөнгийн эврийн худалдааны хууль бус сүлжээг илрүүлэн, таслан зогсоов
Украин улс Хятад руу бөхөн гаргах гэж байна

Өгүүлэл, нийтлэл

Стеффен Цютэр. 2019 оны агаарын судалгаагаар Казакстан дахь бөхөнгийн тоо толгой огцом өссөн үр үр дүн гарчээ

Буянаагийн Чимэддорж ба бусад. Монгол бөхөнгийн тоо толгойн судалгааны шинэ мэдээ

Хантер Доугти ба бусад. Сингапур дахь бөхөнгийн эвэр хэрэглэгчдийн онцлог, сэдэл, худалдан авах зан төрх

Дмитрий Добринин, Оксана Сукова. Каспийн тэнгис орчмын баруун хойд хэсгийн бөхөнгийн популяцийг дрон ашиглан тоолов

Ирина Калюцная ба бусад. Элтон нуур: Орос улсад шинээр байгуулагдсан шим мандлын нөөц газрын бөхөнгийн хамгаалалд оруулах хувь нэмэр

Шинээр хэвлэгдсэн бүтээлүүд

Мэдээ

2019 оны SCA хөтөлбөрийн жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөр болон залуу байгаль хамгаалагч хөтөлбөрийн ялагчдыг танилцуулж байна

Док. Юрий Грачев-д 80 насны ойн баярын мэнд хүргэе!

Бөхөнгийн баатрууд: Доктор Дэвид Маллон

Гэгээн дурсгалд: Шинжлэх ухааны доктор Б. Лхагвасүрэн

Редакцийн зөвлөл: **Хятад:** Гуйхон Джан (guihongzhang@foxmail.com) Куйланг Боловсрол төв & профессор Жанг Зиган (zhigangjiang@vip.sina.com) Хятадын ШУА, Амьтан судлалын хүрээлэн; **Казакстан:** Док. Ю. А. Грачев & профессор А. Бекенов, Амьтан судлалын хүрээлэн (teriology@mail.ru). **Монгол:** Док. Б. Бүүвэйбаатар (buuveibaatar@wcs.org), Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Б. Чимэддорж, (chimeddorj@wwf.mn), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; **ОХУ:** Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (saiga-center@mail.ru) & док А. Луцкеина, Экологи эволюцийн хүрээлэн (saigak@hotmail.com); **Узбекистан:** Е. Бикова [Гүйцэтгэх редактор] & док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн (esipov@xnet.uz); **Их Британи:** Профессор Е. Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Оксфордын их сургууль (ej.milner-gulland@zoo.ox.ac.uk) & док. Давид Маллон [редактор], ДБХХ, Туруутны мэргэжлийн баг (d.mallon@zoo.co.uk). График дизайныг Динара Адилова (4dinaa@gmail.com).

Бүх өгүүлэл, нийтлэлүүдийг зургаан орны хэл дээр авах бөгөөд ebykova67@mail.ru хаяг руу болон аль нэг редактор луу илгээж болно. Энэхүү мэдээ, сэтгүүл жилд 2 удаа хэвлэгддэг. Өгүүлэл, нийтлэл бичих журмыг Англи болон Орос хэл дээр www.saiga-conservation.com хаягаас болон бусад редакторуудаас авч болно. Асуулт болоод дэвшүүлэх санаа байвал ерөнхий редактор Елена Букова (ebykova67@mail.ru)-аас болон өөрийн орны Бөхөнгийн мэдээг хариуцсан редакторуудтай холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр at www.saigaresourcecentre.org, www.saiga-conservation.com болон www.saigak.biodiversity.ru/publications.html сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас Англи, Казах, Хятад, Монгол, Орос, Узбек хэл дээр авч болно.

Дугаарын онцлох сэдэв

Бөхөнгийн олон улсын худалдааны асуудлыг Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенци (CITES)-ийн Талуудын шийдвэрт тусгах нь эерэг алхам мөн үү?

Редакцийн тэмдэглэл: Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенц (CITES)-ийн Талуудын 17-р бага хурал 2019 оны 8-р сард болж, хурлаар бөхөнгийн асуудлыг хэлэлцсэн. Талуудын уулзалтаар бөхөн тархсан улс орнууд санал нэгтгэйгээр бөхөнг конвенцын 2 дугаар хавсралт (зохицуулалттай худалдаа)-нд хэвээр үлдээж харин экспортыг тэглэх шийдвэрийг гаргасан. Энэ нь бөхөн, түүний эд эрхтэнг олон улсад худалдаалахыг хориглоход үр дүнтэй арга хэмжээ болно хэмээн үзэж байна. Иймд бид энэхүү шийдвэрийг гаргахад биечлэн оролцсон албаны хоёр хүнтэй уулзан, тэдний ялгаатай байр суурийг сонирхлоо. Хэдийгээр CITES-ийн зүгээс бөхөнгийн хоёр зүйл бий (*Saiga tatarica*, *Saiga mongolica*) хэмээн үздэг хэдий ч IUCN болон SCA нь одоогийн байгаа генетик мэдээлэлд үндэслэн бөхөнгийн нэг зүйл бий (*Saiga tatarica*) бөгөөд энэ нь *tatarica* болон *mongolica* хоёр дэд зүйлд хуваагдана.

Энхтүвшингийн Шийлэгдамба Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг. Улаанбаатар хот, Монгол улс eshiilegdamba@wcs.org

Монгол орны хувьд бөхөн соёл, түүх, экологийн чухал ач холбогдолтой амьтан. Саяхныг хүртэл бөхөн Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан жагсаалтын устаж байгаа ангилалд багтаж, Монголын тал нутгийг оролцуулан Евроазийн өргөн уудам орон зайд амьдарч байсан. Мөстлөгийн үед үст хирс, арслан заантай зэрэгцэн амьдарч, түүхэн тархац нутаг нь Юкон, Аляскад хүрч байсан энэ эртний амьтан өнөөдөр халдварт өвчин, хулгайн ангаас болж болж тоо толгой нь эрчимтэй хорогдсон.

2019 оны 8 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд Женев хотод болсон CITES-ийн Талуудын 18 дугаар бага хуралд тус конвенцод нэгдсэн орсон 128 орны төлөөлөл оролцож ховордсон амьтдын худалдааг зохицуулах асуудлуудыг хэлэлцсэн. Тус бага хуралд Монголын засгийн газрын төлөөлөл оролцож бөхөнгийн хамгааллыг дээшлүүлэх үүднээс уг зүйлийг конвенцын II хавсралтаас I хавсралтад шилжүүлэх саналыг өргөн барьсан. Төслийн саналыг АНУ-ын засгийн газар дэмжин, талуудад хамтран танилцуулсан. Бөхөн тархсан Орос, Казахстан, Узбекистан, Туркменстан, Монгол зэрэг улс орнууд бөхөнгийн популяцийн өнөөгийн төлөв байдлыг хэлэлцэн, түүний эд эрхтний худалдааны асуудлыг хөндсөн. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн тоо толгой зарим орнуудад тухайлбал Казахстан улсад өсөж буй хэдий ч бөхөнг 1 дүгээр хавсралтад шилжүүлэх санал дэмжигдээгүй юм. Харин бөхөнг анх 1994 онд конвенцын 2 дугаар хавсрал-

тад оруулсан статусыг хэвээр үлдээж, экспортыг тэглэхийг санал нэгтэй баталсан. Конвенцын II хавсралтад гол төлөв худалдааг нь хязгаарлах шаардлагатай зүйлүүдийг багтаадаг. Бөхөнгийн эврийн худалдааг таслан зогсоох замаар хамгааллыг нь нэмэгдүүлснээр энэ зүйлийг устаж үгүй болох аюулаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Бөхөн хамгаалал нь Монголын засгийн газар, ард түмний хувьд чухал асуудал тул бид бөхөн тархсан улс орнууд, конвенцын талууд, түүнчлэн АНУ-ын засгийн газарт энэхүү үйл хэрэгт дэмжлэг үзүүлж буй талархаж байна. Монгол улс анх 1996 онд CITES-ийн конвенцод нэгдэн орсон бөгөөд бидний өргөн барьж буй санал нь тус орны хувьд талуудад дэвшүүлж буй анхных юм. Хэдийгээр Монгол нь хүн ам цөөтэй хөгжиж буй улс боловч Төв Азийн хэмжээнд биологийн олон янз байдлаар баялаг юм. 1970-аад оны үед бөхөн нь дэлхийн хэмжээнд өргөн тархалттай байсан төдийгүй тоо толгой нь 1 саяд хүрч байсан. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд тоо толгой нь хэд хэдэн удаагийн давтамжтай огцом буурч улмаар 2000 оны эхэн гэхэд ердөө 50,000-аар тоологдох болсон.

Бөхөнг тэртээ 25 жилийн өмнө CITES-ийн конвенцын II хавсралтад анх бүртгэгдсэнээс хойш нэлээд зүйлс өөрчлөгдсөн. Өнгөрсөн хэдэн жилүүдэд бөхөн нийт тархац нутгийнхаа хэмжээнд бөөнөөрөө хоргодох болсон. 2015 онд Казахстаны төв хэсэгт *Pasteurella multocida* бактериар үүсгэгд-

Дугаарын онцлох сэдэв: үргэлжлэл

сэн халдвар өвчин дэгдсэний улмаас 200,000 гаруй бөхөн нэг дор хорогдсон. Түүнчлэн 2016 онд бог малын мялзан өвчин (Peste des Petits Ruminants буюу PPR) Монголд дэгдэж улмаар бөхөнгийн популяцийн 80 орчим хувь богино хугацаанд хорогдсон бөгөөд 2018 оны 4-р сарын байдлаар Монгол орны хэмжээнд 5,142 бөхөн тоологдсон (Pruvot нар. 2020).

Монгол орны баруун бүсэд PPR өвчин өргөн хүрээтэй тархаж байгаа бөгөөд бөхөнгийн тоо толгойн хорогдлын 80-90 хувийг эзлэх болсон. Хэдийгээр судалгааны ажлууд эрчимтэй хийгдэж байгаа ч PPR өвчин бөхөнгийн бусад популяцид дэгдэх нь зөвхөн цаг хугацааны асуудал болоод байна. Эдгээр болон бусад өвчнүүд бөхөнгийн популяцид аюул занал учруулсаар байгаагийн дээр хулгайн ан, хууль бус худалдаа явагдсаар байгаа нь энэ зүйлд хэтэрхий их дарамт болж байна.

Сүүлийн 4 жилд хийсэн судалгаагаар Казахстан улсын бөхөнгийн тоо толгой өссөн дүнтэй гарсанд бид баяртай байгаа хэдий ч халдвар өвчин дахин дэгдэж улмаар бөхөн тархац нутгийнхаа хэмжээнд олноор хоргодох вий гэдэгт санаа зовниж байна. Халдварт өвчнөөс гадна хулгайн ан, эврийн хууль бус худалдаа, дэд бүтцийн хөгжил зэрэг олон аюул занал бөхөн тархсан улс орнуудад нэмэгдсээр байна.

Азийн уламжлалт анагаах ухаанд эврийг нь түүхий эд болгон ашиглаж байгаа нь бөхөн хулгайгаар агнах үндсэн шалтгаан болж байна. Монгол орны



Хурлын 1 дүгээр танхимд төлөөлөгчид бөхөн, анааш, заан зэрэг зарим зүйл амьтдын талаар хэлэлцүүлэг өрнүүлж байна. Зургийг: Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн (IISD)

хэмжээнд 3,000 орчим болтлоо цөөрсөн бөхөнгийн популяци цаашлаад хууль бус эсвэл өөр бусад худалдааны золиос болох вий гэдэгт бид маш их санаа зовж байна. Зарим улс оронд явагдаж буй аливаа худалдаа бөхөнгийн эврийн эрэлтийг нэмэгдүүлж улмаар хулгайн агнуур гарах нөхцөлийг үүсгэж байгаа бөгөөд энэ нь мэнд үлдэхийн төлөө тэмцэж буй Монгол бөхөнгийн жижиг популяцийг устах аюулд хүргэж болзошгүй. Саяхан Казахстан улсад хоёр байгаль хамгаалагч хулгайн анчдад алуулсан хэрэг гарсан нь үнэхээр аймшигт зүйл юм.

Монгол улс нь хүн ам цөөтэй, өргөн уудам нутаг дэвсгэртэй бөгөөд энэ нь эргүүл хяналтын ажлыг явуулахад хүндрэл учруулдаг. Бөхөн аливаа халдварт өвчинд эмзэг, мөн эврийн эрэлт өндөр байгаа энэ үед Женевт болсон хурлын үеэр хийсэн алхам нь уг зүйлийг хамгаалахад чиглэсэн чухал шийдвэр юм.

Арилжааны зорилготой экспортыг тэглэх хүсэлтийг санал нэгтэй хүлээн авч дэмжсэн бөхөн тархсан улс орнуудад Монгол улс гүнээ талархаж байна. Монгол улс зэрлэг амьтдыг тогтвортой ашиглахыг дэмжиж байгаа бөгөөд гагцхүү тухайн популяцийн тоо толгой тогтвортой, ашиглах хэмжээнд байх ёстой. Тоо толгой нь хэт цөөрсөн Монгол бөхөнгийн популяцийн хувьд бөхөнгийн эврийг худалдаалах тухай асуудал нь цагаа олоогүй хэрэг юм.

CITES-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга нээлтийн үгэндээ "CITES нь шинжлэх ухааны мэдээ, баримтад үндэслэн бөхөн мэтийн өмнө нь төдийлөн анхааралд өртөж байгаагүй зүйлүүд чиглэсэн шийдвэрүүдийг гаргах болно" гэдгийг онцолсон. Бөхөн хамгааллыг сайжруулах уриалгыг бөхөнгийн тархсан улс орнууд болон CITES-ийн бусад талууд дэмжсэнд бид маш баяртай байна. Төв Азийн түүх, соёл, экологийн чухал ач холбогдолтой зүйлүүдийн нэг болох бөхөн хамгаалах үүрэг хүлээсэн үеийн төлөөлөл гэдгээрээ бид бахархаж байна. Түүнчлэн хурлын үеэр гарсан аливаа шийдвэрүүд нь судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэн гарсанд бид мөн баяртай байна. Ингэснээр манай гараг дээр олон мянган жилийн турш амьдарч ирсэн энэ гайхамшигтай амьтан цаашид ч Төв Азийн бэлэг тэмдэг болон оршоор байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дугаарын онцлох сэдэв: үргэлжлэл

Антон Межнев ОХУ-ын Байгалийн нөөц, байгаль орчны яам amezhnev@mail.ru

Казахстан улсад хамгааллын үйл ажиллагаа сайжирсны үр дүнд Орос-Казахстаны хил орчмын бөхөнгийн хоёр популяци (Волга-Урал, Бетпак-Дала)-ийн тоо толгой эрс нэмэгдсэн. Одоогийн байдлаар энэ бүс нутагт 300,000 орчим бөхөн бий гэсэн судалгааны үр дүн гарсан бөгөөд ирэх хоёр жилд энэ тоо 500,000 болж өсөх магадлалтай байна. Бөхөнгийн тоо толгой өсөж энэ босгыг давах үед тогтвортой ашиглалтын асуудал гарч ирнэ. Тоо толгой өсөхийн хэрээр эрсдэлүүд давхар бий болох бөгөөд эдгээрийг шийдэхэд чиглэсэн санхүүжилтийн асуудал мөн гарч ирнэ. Бөхөнгийн экспортод хориг тавих нь бөхөн тархсан улс орнууд уг зүйл болон түүний амьдрах орчныг нь хамгаалах чиглэлд хамтран ажиллах боломжийг хаана. Өөрөөр хэлбэл бөхөнгийн статусыг дээшлүүлэх нь дунд болон цаашлаад урт хугацаандаа дэлхийн популяцийн 95%-ийг агуулдаг бөхөнгийн хоёр том популяцид асуудал хүндэрнэ.

Иймээс Казахстан, Орос улсууд бөхөн Хавсралт I рүү шилжүүлэхийн эсрэг байр суурьтай байгаад зогсохгүй бусад улс орнуудаас ирсэн саналыг тууштай эсэргүүцсээр ирсэн. 2018 оны сүүлчээр Монгол улс (байгаль цаг агаарын тааламжгүй нөхцөл, халдварт өвчин, хулгайн ангийн улмаас тоо толгой нь эрс цөөрсөн) албан ёсоор хүсэлт гаргах үед Казахстаны ХАА-н яамны харьяа Зэрлэг амьтан, ойн хэлтэс болон ОХУ-ын Байгалийн нөөц, хүрээлэн буй орчны яам бөхөнгийн статусыг



ОХУ-ын төлөөлөгч Антон Межнев. Зургийг: Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн (IISD)

дээшлүүлэх саналыг эсрэг байсан. Мөн Монгол улс төслийн санал боловсруулахдаа алдан гарган нэр томъёог *Saiga tatarica* хэмээн оруулсан нь *Saiga borealis* буюу Монгол бөхөнтэй хамааралгүй болж байна.

Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) зүгээс гаргасан төслийн саналыг АНУ-ын тал дэмжиж байгаа нь тэдний зүгээс үзүүлж буй нөлөө гэж харж байна. Казахстан болон ОХУ CITES-ийн талуудын 18 дугаар хурлын бэлтгэл ажлын хүрээнд конвенцын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар болон "Нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенц"-ийн хамтран Германы Вилмийн арал (2019 оны 4-р сарын 1-4)-д зохион байгуулсан бөхөн хамгааллын семинар, Хамтын нөхөрлөлийн орнуудын бүс нутгийн семинар (Беларус, Минск, 2019 оны 4-р сарын 23-25)-ийн үеэр хоёр ч удаа өөрсдийн байр сууриа хатуу илэрхийлсэн. Эдгээр хоёр уулзалтын үеэр бидний байр суурийг Узбекистан болон бусад бөхөн тархсан улс орнууд дэмжсэн. Вилм арал дээр болсон семинарын үеэр Хятад (гол хэрэглэгч орон)-ын төлөөлөгчид мөн бөхөнгийн статусыг дээшлүүлэх саналын эсрэг байсан. Мөн тэдний дурдсанаар Хятад улс дотоодын бөхөнгийн эврийн хууль бус худалдаанд хяналт тавихын сацуу одоогийн байгаа эврийн нөөцөө бүртгэлжүүлэх тэдгээрт бичил чип зүүх гэх мэт дорвитой арга хэмжээнүүдийг авч буйгаа онцолсон. CITES-ийн Нарийн бичгийн дарга нарын газар Монголоос гаргасан төслийн санал нь Хавсралт 1-ийн зарим шалгуур үзүүлэлт болон худалдааны зохицуулалттай холбоотой бусад хэд хэдэн заалттай зөрчилдөж байгааг хэлсэн. Хэдийгээр уг төслийн санал дэмжигдээгүй ч Монгол болон АНУ-ын зүгээс бөхөнгийн хоёр зүйлд энэхүү саналыг хамааруулах тал дээр тууштай зогсоор байна.

ОХУ-ын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн яам АНУ-ын байгаль орчны байгууллага (USFWS)-тай төслийн саналын талаар хоёр удаа видео хурал хийсэн бөгөөд хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр бөхөнгийн статусыг дээшлүүлэх саналыг экспортыг тэглэх болгон өөрчилсөн. Мөн Европын холбооны элчин сайдуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтаас уг асуудлыг нухацтай үзэж байж шийдвэр гаргахыг зөвлөсөн. Энэ бүхнээс үзэхэд CITES-ийн

Дугаарын онцлох сэдэв: үргэлжлэл

18 дугаар хурлын үеэр бөхөнгийн статусыг дээшлүүлэх тал дээр талууд нэгдсэн саналд хүрээгүй.

CITES-ийн 18 дугаар хурлын өмнө буюу 8 сарын 18-ны өдрийн орой хоёр арга хэмжээг нэг зэрэг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнүүдийн зорилго нь сонирхогч талуудад нөхцөл байдлын талаар санал бодлоо солилцох боломжийг олгоход чиглэсэн.

Эхний арга хэмжээний үеэр Монгол болон АНУ өөрсдийн өргөн барьж буй төслийн саналаа олон нийтэд танилцуулсан. АНУ-ын байгаль орчны байгууллага (USFWS) болон CITES-ийг төлөөлөн Розмари Гнам болон Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөн төслийн саналыг боловсруулсан Сузан Лийбэрман нар уг уулзалтыг нээж үг хэлсэн. Үүний дараа Монгол улсыг төлөөлөн П. Цогтсайхан, Ш. Энхтүвшин нар төслийн санал, Монгол бөхөнгийн өнөөгийн төлөв байдал, Peste des Petits Ruminants өвчний тухай танилцуулга хийсэн. Төлөөлөл нар төслийн саналыг дэмжсэн байраа сууриа илэрхийлсэн. Холбогдох асуудлаар ОХУ-ын өгсөн санал, байр суурийг хатагтай Р.Гнамын нэлээд хүчтэй эсэргүүцэж, саналаа дэмжүүлэх үүднээс өөрийн баримт мэдээллээ хэдэнтээ давтаж байсан.

Энэхүү уулзалтыг залгаад Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенц (CMS) “Бөхөн хамгаалах санамж бичгийг хэрэгжүүлэхэд гарч буй амжилт ба сорилт” сэдэвт арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний гол зорилго нь



Монгол улсын төлөөлөл П. Цогтсайхан бөхөнгийн статусыг дээшлүүлэх тухай төслийн саналыг танилцуулж байна. Зургийг: Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн (IISD)

бөхөн хамгаалах, тогтвортой ашиглахад уг санамж бичгийн гүйцэтгэх үүргийг олон нийтэд танилцуулахад чиглэсэн. Арга хэмжээг нээж Еми Фрэнкл үг хэлсний дараа Мелани Вирчу санамж бичгийн тухай танилцуулга хийсэн. Үүний дараа Е. Ж. Милнер-Гулланд бөхөнгийн популяцийн төлөв байдлын тухай илтгэлийг улс орон бүрээр танилцуулсан бол А. Межнев санамж бичгийн хэрэгжилт ОХУ-д хэр байгаа тухай мэдээлэл хийсэн. Хэдийгээр бөхөнгийн статусыг дээшлүүлэх асуудал уг уулзалтын зорилго биш байсан ч хэлэлцүүлгийн үеэр оролцогчид энэ асуудлыг олонтоо хөндөж байсан. Арга хэмжээний үеэр энэ асуудалд Европын холбооны төлөөлөгчдийн байр суурь тодорхойгүй хэвээр байгаа нь харагдаж байсан.

CITES-ийн үндсэн хуралдаан эхлэхийн өмнө конвенцын талууд (бөхөн тархсан улс орон болон эд, эрхтнийг хэрэглэгч улс орнууд) “экспортыг тэглэх” нь бөхөнгийн статусыг дээшлүүлэх чухал алхам болохыг зөвшөөрч санал нэгдсэн. Тиймээ үндсэн хуралдааны өмнө АНУ-ын төлөөлөл тус саналын тухай талууд дэмжиж буй эсэхийг баталгаажуулан, улмаар чуулганд өргөн барьсан.

Төслийн талаарх мэтгэлцээн 8-р сарын 22-ны өдрийн өглөө болсон. Монголын төлөөлөгчид уг саналыг танилцуулсны дараа АНУ-ын төлөөллүүд энэхүү санал бөхөнгийн хоёр зүйлийг хамтад нь хамрах тухай байр сууриа илэрхийлсэн. Энэ нь богино хугацаанд нэлээд ширүүн маргаан өрнүүлсэн бөгөөд CITES-ийн нарийн бичгийн дарга нарын газар уг мэдэгдлийн эсрэг байр суурьтай байсан. Амьтны хорооны мэргэжилтэн бөхөнгийн өнөөгийн ангилал зүйн талаарх үзэл бодлоо илэрхийлсний дараа хурлын дарга АНУ-ын байр суурийг зөвшөөрөх шийдвэр гаргасан. Харин ОХУ-ын тал энэхүү шийдвэрийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлэн уг асуудлыг цаашид хэлэлцэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн.

Дараа нь конвенцын бусад талууд саналтай холбоотой өөрсдийн байр сууриа илэрхийлсэн. Бөхөн тархаагүй эсвэл бөхөнгийн эд эрхтэн хэрэглэдэггүй улс орнууд тухайлбал Афганистан, Бахрейн, Зааны Ясан Эрэг, Гватемала, Израиль, Катар, Сенегал зэрэг улс орны төлөөлөгчид уг саналыг дэмжиж байсан бол харин Казахстан улс хүчтэй эсэргүүцсэн. ОХУ мөн адил саналыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн бөгөөд бөхөнгийн Мон-

Дугаарын онцлох сэдэв: үргэлжлэл

гол улсын бөхөнгөө хамгаалахын төлөө байгаа хүсэл эрмэлзлийг харгалзан үзэж Монгол бөхөнг дангаар нь Хавсралт I-д оруулан харин экспортыг хоёр зүйлийн аль алинд тэглэхийг санал болгосон. ОХУ-ын энэ саналыг Хятад болон Европын Холбоо дэмжсэн.

Бусад талуудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан АНУ байр сууриа өөрчлөн Монгол улстай санал нэгдсэний үндсэн дээр “байгаль дээрх бөхөнгийн бүх популяцийн арилжааны зориулалттай экспортыг тэглэх” гэсэн нөхцөлтэйгөөр бөхөнг Хавсралт II-д үлдээнэ гэдэг нөөц хувилбарыг санал болгосон. Энэ саналд CITES-ийн Нарийн бичгийн дарга нарын газар бага зэргийн засвар оруулан өөрчилсөн ба уг хувилбарыг бөхөн тархсан улс орнууд (Казахстан, Орос, Узбекистан) болон Европын Холбоо, түүнчлэн өмнөх саналыг дэмжиж байсан Афганистан, Израиль зэрэг улсууд дэмжин баталсан. Хятад улс эсрэг байр суурь илэрхийлээгүй хэдий ч энэхүү санал зөвхөн Монгол бөхөнг хамрах ёстой гэдгийг дахин сануулсан. Энэ бүх хэлэлцүүлгийн үр дүнд бөхөнгийн хоёр зүйлийг CITES-ийн Хавсралт II-т хэвээр үлдээх байр суурин дээр талууд санал нэгдэн шийдвэр гаргасан. Уг шийдвэр 2019 оны 11-р сарын 26-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

CITES-ийн хурлаар хэлэлцэх бөхөнтэй холбоотой өөр нэг асуудал бол нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн “Баримт бичиг 86”-ийг хэлэлцэх асуудал байсан юм. Энэ нь CITES болон CSM-ийн хамтран бөхөн хамгаалах чиглэлд хэрэгжүүлж буй дунд хугацааны (2016-2020 болон 2021-2025)

хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэх асуудал байсан.

АНУ-ын зүгээс бөхөн тархсан орнуудад хандан “Баримт бичиг 86”-д дараах зүйлсийг тусгахыг санал болгосон. Үүнд: “2016-2020 оны дунд хугацааны үй ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд бөхөн тархсан орнууд өөрсдийн дотоод дахь бөхөнгийн эд эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний худалдааны хяналтыг сайжруулахын тулд эврийн нөөцийг бүртгэлжүүлэх, бүртгэлтэй үйлдвэрлэгч болон борлуулагчдыг тэмдэгжүүлэх улмаар эдгээр мэдээллүүдийг CITES-ийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргэдэг байхыг санал болгосон. Энэ асуудал дээр талууд бүгд санал нэгдсэн. Бөхөнгийн эд эрхтний худалдаа зөвхөн бөхөн тархсан эдгээр орнуудад бус нийтдээ хууль бус болохоор зарим талаар учир зүйн алдаатай мэт сонсогдож болох юм. Одоогоор бөхөн тархсан улс орнуудын дотоодын зах зээл дээрх эврийг худалдаа ямар нэг байдлаар хяналтад оршдог. Аливаа илэрсэн хууль бус бөхөнгийн эд эрхтнийг бүртгэж, баримтжуулан улмаар шүүхэд шилжүүлдэг. Бөхөнгийн эвэр худалдахыг завдсан аливаа үйлдлийг гэмт хэрэг үздэг. Эдгээр мэдээллүүдийг нэгдсэн хуралдаан дээр АНУ-ын талд өгсөн хэдий ч анх гаргасан саналдаа ямар нэг өөрчлөлт хийгээгүй. Иймд “Баримт бичиг 86”-ийг энэхүү мэдэгдлийн хамт баталсан.



Бөхөнгийн оон. Зургийг: Растислав Машин

Мэдээний булан

Монгол бөхөн хамгаалах хамтын менежментийн зөвлөл байгуулахаар боллоо

Буянаагийн Чимэддорж ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар chimeddorj@wwf.mn

“Шарга-Манханы Байгалийн Нөөц Газар”-ыг устах аюулд ороод байгаа Монгол бөхөн хамгаалах зорилгоор 1993 онд Монгол Улсын Их Хурлын тогтоолоор байгуулсан. Уг байгалийн нөөц газар (БНГ)-ийн Манханы хэсэг нь Ховд аймгийн хоёр сумын нутаг дэвсгэрийг хамрах бол Шаргын говь нь Говь-Алтай аймгийн дөрвөн сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд эдгээр нь Алтай Соёны эко-бүсэд оршдог. Хэдийгээр эдгээр хоёр газар хоорондоо холбоогүй, зайтай оршдог ч Монгол бөхөнгийн тархац нутгийн цөм хэсэг тооцогддог.

Хуулийн хүрээнд БНГ нь улсаас санхүүжилт авдаггүй, харин менежментийн үйл ажиллагааг тухайн орон нутаг (аймаг, сум) хариуцан зохион байгуулах заалттай. Орон нутгийн зүгээс тус нөөц газарт хуваарилагдах төсөв хангалтгүй байдгаас шалтгаалан БНГ-ын хамгааллын менежмент хангалтгүй, орон нутгийн удирдлагын идэвх санаачилга дутмаг байдаг. Шарга-Манханы БНГ-ын хамгаалалтын захиргаа байхгүй учраас өнөөдрийг хүртэл орон тооны байгаль хамгаалагчгүй явж ирсэн. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар (ТХ-

ГНУГ), ДБХС-ийн Монгол дахь Хөтөлбөрийн газар хамтран 2019 оны 5-р сарын 8-ны өдөр бөхөнгийн хамгааллын менежментийн асуудлаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Уулзалтанд БОАЖЯ-ны ТХГНУГ, Ховд, Говь-Алтай аймгийн төлөөлөл болон судлаачид, олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон.

Уулзалтаар хэлэлцсэн гол асуудлуудын нэг бол Шарга-Манханы БНГ-ын статусыг дээшлүүлэн Байгалийн цогцолборт газар (БЦГ) болгох явдал бөгөөд уг саналыг ТХГНУГ-т тавьсан. Хэрэв БНГ-ын статусыг дээшлүүлсэн тохиолдолд хамгаалалтын захиргаа байгуулагдаж, улсаас төсөв санхүүжилт хуваарилагдах болно. Үүний хариуд улс орны эдийн засгийн нөхцөл хүнд байдлаар байгаа энэ үед уг хүсэлтийг хүлээн авахад төвөгтэй гэдгийг ТХГНУГ-ын төлөөлөл мэдэгдсэн. Иймд уулзалтаар талуудын оролцоог нэмэгдүүлж БНГ-ын менежментийг сайжруулах нь зүйтэй гэдэг зөвлөмжийг оролцогчид гаргасан. Үүний тулд хамтын менежментийн зөвлөл байгуулж, түүний бүтэц бүрэлдэхүүнийг тогтоож, ажиллах журмыг боловсруулах ажлын хэсэг байгуулах хэрэгтэй гэж үзсэн.

“Бөхөнгийн өдөр” 2019

2019 оны 4-6 сарын хооронд Узбекистан, Казахстан, Орос, Монгол улсад “Бөхөнгийн өдөр”-ийг “Сурагчдын клуб”-ууд амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь аль хэдийн уламжлал болсон бөгөөд жилээс жилд өргөн тэмдэглэгдэж байна. Энэ жилийн арга хэмжээнд 30 гаруй клуб, 2000 гаруй хүн оролцсон.

Узбекистан улсын “Бөхөнгийн өдөр”

Александр Букварева Бөхөн Хамгаалах Холбоо bukvarevaa@gmail.com

“Бөхөнгийн өдөр”-ийн арга хэмжээг 5-р сард Узбекистан улсын Жаслик тосгоны төв талбайд дөрвөн клуб хамтран зохион байгуулсан. Бөхөнгийн өдрийн өмнөх орой «Бөхөнгийн цом 2019» хөл бөмбөгийн тэмцээн, «Би бөхөнд хэрхэн тусалж чадах вэ» сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, бөхөнгийн

онцлогийг харуулсан танин мэдэхүйн хичээлүүд, “Хаана? Юу? Хэзээ?” асуулт хариултын тэмцээн зэрэг хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулагдсан. Асуулт хариултын тэмцээнийг мөн Нукус хот болон Каракалпакия тосгонд зохион байгуулсан.

Мэдээний булан: үргэлжлэл

“Бөхөнгийн өдөр” эсээ бичлэгийн уралдааны дүнг зарласан. Түүнчлэн хүүхдүүд “Хээрийн үлгэр” хоёр ангит хүүхэлдэйн кино үзэж сонирхон өөрсдийн сэтгэгдлээ хуваалцсан. Мөн энэ өдөр бүлгэмд шинэ гишүүдийг элсүүлэн авсан бөгөөд дуу, бүжиг, урлагийн тоглолтын үзүүлбэрүүд арвин байсан. Энэ арга хэмжээний төгсгөлд хүүхдүүд эцэг эх болон багш нарын хамт бөхөнгийн магтаал дууг дуулсан.



Узбекистан улсын Жаслык тосгоны “Бөхөнгийн өдөр”.
Зургийг: БХХ

Казахстан улсын “Бөхөнгийн өдөр”

Мухит Суттибаев Казахстан улсын Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Холбоо (АСВК) mukhit.suttibayev@acbk.kz

Казахстан улсад “Бөхөнгийн өдөр”-ийг нийт 11 сурагчдын бүлгэм хамтран 6 дугаар сард сургуулийнхаа хээрийн дадлага ажлын хүрээнд амжилттай тэмдэглэлээ. Хүүхдүүд баг болон хуваагдаж хоорондоо өрсөлдөв. Казахстаны биологийн олон янз байдлыг хамгаалах холбоо (АСВК)-ны гаргасан хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүд төрөл бүрийн сонирхолтой даалгаврыг гүйцэтгэсэн. Хүүхдүүд уг арга хэмжээнд зориулан гаргасан зурагт хуудас, танилцуулга, товхимлыг ашиглан, төрөл бүрийн тэмцээн уралдаанд идэвхтэй оролцох замаар бөхөнгийн тухай нэлээд өргөн мэдлэгтэй болсон. Сургалтын хөтөлбөрт хээрийн экосистем дэх тодорхой зүйлүүдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох даалгавар хүртэл багтсан. Түүнчлэн зэрлэг амьтдын зан төрхийг харуулах даалгавар тухайлбал “лаа” хэмээн нэрийдсэн бөхөнгийн харайлтыг биечлэн үзүүлэх даалгавар мөн орсон. Хүүхдүүд цэгүүдийг холбох замаар бөхөнгийн зургийг гар-



Бөхөнгийн өдөр. Бегимбет. Зургийг: АСВК

гаж, тэдгээрийг будгаар тодотгож, зурагт бөхөн юу хийж байгааг тайлбарласан. Мөн тэд амьтдыг сүүдрээр нь тодорхойлох даалгаврыг гүйцэтгэсэн. Бөхөнгийн өдрийн хамгийн чухал хөтөлбөр бол “залуу мөрдөгч” гэж нэрлэсэн зэрлэг амьтдыг биеийн хэлбэр, онцлог шинжээр нь алсаас тодорхойлох даалгавар байсан.

Оросын “Бөхөнгийн өдөр”

Надежда Пюрвенова Бөхөн Хамгаалах Холбоо arylova@gmail.com

ОХУ-д “Бөхөнгийн өдөр”-ийг 4 дүгээр сарын сүүлээс 5 дугаар сарын сүүл хүртэлх хугацаанд зохион байгуулсан сурагчдын зургаан бүлгэм идэвхтэй оролцсон. Эдгээр сурагчдын бүлгэмүүд нэгдсэн удирдамжийн хүрээнд өөр өөрсдийн хөтөлбөрийг боловсруулан гаргасан. Хөтөлбөрт мэдээлэл тү-

гээх хэсэг (бөхөнгийн тухай лекц, танилцуулга, видео); сэтгэхүйн ба бүтээлч сэтгэлгээний хэсэг (экологийн элч, асуулт хариулт, уралдаан тэмцээн); урлаг, спортын хэсэг; шагнал гардуулах ёслол (диплом, шагнал); идэвхтэй амралт, завсарлага гэсэн хэсгүүд багтсан.

Мэдээний булан: үргэлжлэл

Түүнчлэн флаш-моб бүжиг, дугуйн аялал, театрчилсан тоглолтууд багтсан. Клубүүдийн дунд байгаль хамгаалал ялангуяа бөхөнгийн тухай ярилцлага хамгийн түгээмэл байлаа. Хүүхдүүдэд өөрсдийн авьяас чадвараа харуулахаас гадна олон шинэ зүйл сурах боломжийг энэ арга хэмжээ олголоо. Энэ жилийн наадмын арга хэмжээг зохион байгуулахад олон ажиллаж ирсэн туршлагатай клубүүдээс гадна шинээр байгуулагдсан залуу клубүүд ч идэвхтэй оролцов.



Лиман тосгонд болсон унадаг дугуйн уралдаан. Гэрл зургийг "Возрождение" Зэрлэг амьтдын клуб

Монголын "Бөхөнгийн өдөр"

Буянаагийн Чимэддорж ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар chimeddorj@wwf.mn

ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар "Бөхөнгийн өдөр"-ийг уламжлал ёсоор 4-р сард тэмдэглэсэн. Энэ жилийн арга хэмжээг Говь-Алтай аймгийн Төгрөг суманд зохион байгуулж, Алтай-Саяны бүсийн 13 эко клубийн 100 гаруй гишүүд оролцож, өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийсэн ажлаа дүгнэсэн.

2018 онд хүүхдүүд зэрлэг амьтад, түүний дотор бөхөн ундаалдаг байгалийн булаг шандын эхийг хамгаалах, тохижуулах аяныг амжилттай зохион байгуулсан. Энэ нь Монгол улсад сургуулийн сурагчдаас гарсан анхны санаачилга байсан бөгөөд үүнд ДБХС дэмжсэн үзүүлсэн. Хүүхдүүд орон

нутгийн малчдыг энэхүү санаачилгад татан оролцуулж чадсан нь тэдний байгаль хамгаалах үйлсэд нь ихээхэн урам өгсөн. Эко клубийн гишүүд байгаль хамгаалах ажлын хүрээнд «хуванцар сав, баглаа боодол»-оос татгалзах аян өрнүүлснийг БОАЖЯ өндрөөр үнэлсэн. Монголын эко клубийн гишүүд байгаль орчин, тэр дундаа бөхөнг хамгаалахын төлөө өөрсдийн хийсэн зүйл, санал санаачилгаараа бахархаж, улам бүр хичээн ажиллахаа илэрхийлж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: <http://mongolia.panda.org/en/news/?uNewsID=346412> хаягаар орно уу.



"Бөхөнгийн өдөр" сэдэвчилсэн зурагт хуудасны танилцуулга. ДБХС-гийн Монголд дахь хөтөлбөрийн газар

Бөхөн тархсан орнуудад зохион байгуулагдсан "Бөхөнгийн өдөр" арга хэмжээ идэвхтэй оролцож ирсэн хүүхдүүдэд шагнал гардуулах ёслолын ажиллагаагаар өндөрлөж, тэдэнд шагнал, гэрчилгээ, ном, бусад зүйлсийг гардуулсан. Мөн 2019 оны "Бөхөнгийн өдөр" арга хэмжээ хүүхдүүдэд олон сайхан дурсамжийг үлдээснээс гадна ирэх жилийн арга хэмжээгээ хэрхэн тэмдэглэх санаагаа ч тэд бас хэдийн олжээ.

Мэдээний булан: үргэлжлэл

"3800 Монгол бөхөнгийн төлөө хамтдаа гүйлээ"

Буянаа Чимэддорж ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар chimeddorj@wwf.mn

Монгол бөхөнг хамгаалахад олон нийт болон шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах зорилгоор ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар, Хууль сахиулахын их сургуулийн оюутнууд хамтран 2019 оны 5-р сарын 18-ны өдөр «Дэлхийд ганцхан Монгол бөхөнгөө хамгаалцгаая» уриан дор олон улсын марафон гүйлтийг зохион байгуулсан. Гүйлтэд оролцож буй оюутнууд "Бид энэ удаа хүсэл зорилгоо нэгтгэн Монгол бөхөнгийнхөө төлөө гүйж байна. Дэлхийд 3800-хан үлдээд байгаа энэ нэн ховор амьтныг хамгаалах ажилд одоо л анхаарал хандуулахгүй бол оройтож мэднэ. Бүгдээрээ нэгдэж монгол бөхөнгөө аварцгаая" хэмээн ярьж байна.

Монгол бөхөнг аврахын тулд түүний үржил, төлөлт явагддаг газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, цаг агаар болон бусад болзошгүй эрсдэлээс авран хамгаалах стратеги боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол бөхөн түүхэн тархац нутагт нь сэргээн нутагшуулах за

маар тусгаар популяци үүсгэх нь эрсдэлийг даван туулах чухал ажил болохыг эрдэмтэн, судлаачид хүлээн зөвшөөрч байгаа юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: <http://mongolia.panda.org/en/news/?uNewsID=348171> хаягаар орно уу.



Монгол бөхөнг хамгаалах зорилготой 12 дахь удаагийн марафон гүйлт. Зургийг ДБХС-ийн Монгол дахь Хөтөлбөрийн газар

"Степнойн тандалт судалгаа" төсөл хэрэгжиж эхэллээ!

Бабетте Фюрер Бөхөн Хамгаалах Холбоо babette971@hotmail.com

Бөхөнг хамгаалах холбооны 2019 оны жижиг төслийн хүрээнд санхүүжигдсэн "Степнойн тандалт судалгаа" төсөл хэрэгжиж эхэллээ. Тус нөөц газрын зэрлэг амьтад тэдгээрийн дотор бөхөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах зорилгоор автомат камер суурилуулан мониторинг судалгааг эхлүүлээд байна. Автомат камерын зураг, бичлэгийг бөхөнгийн талаарх сургалт сурталчилгааны материал болон зэрлэг амьтдын тархалт, зан төрхийг судлахад ашиглаж байна. «Степной» тандалт судалгааны төслийн зорилго нь бөхөнг олон нийтэд сурталчлах замаар хулгайн ан болон бусад аюул заналыг бууруулахад оршино. Автомат камерын мэдээг Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг"-ийн хэрэгжүүлдэг иргэдэд түшиглэсэн "Instant Wild" судалгааны мэдээллийн санд нэгтгэж оруулсан. Энэхүү платформ нь дэлхийн өнцөг булан




Владимир Калмыков болон Бабетте Фюрер нар Степной нөөцийн газарт задгай усны ойролцоо автомат камерыг суурилуулж байна. Зургийг: Галина Калмыкова

Мэдээний булан: үргэлжлэл



Хоёр бие гүйцсэн шаргачин болон 2019 онд төрсөн гурван залуу ооноос бүрдсэн бөхөнгийн жижиг сүрэг. Зургийг Степной нөөц газрын автомат камерын зураг.



Артезийн худгаас задгайран урсаж байгаа уснаас ундаалж буй бөхөнгийн шаргачин. Зургийг Степной нөөц газрын автомат камерын зураг.

бүрт байгаа гишүүддээ автомат камерын өгөдөлд дүн шинжилгээ хийхэд туслан оролцох боломжийг олгодог.

Автомат камерын зургийн тусламжтай амьтдыг зүйл, тоо толгой, хүйс (зарим тохиолдолд)-ээр тодорхойлох боломжтой. Instant Wild төслийн интернэт хуудсанд Бөхөн Хамгаалах Холбооны вэб хуудас руу шилжих холбоосыг байршуулсан бөгөөд энэ нь бөхөнг олон нийтэд таниулж улмаар дэмжлэг авах боломжийг бүрдүүлнэ.

Одоогийн байдлаар зэрлэг амьтад задгай усыг ашиглах өдрийн (аль зүйл өдрийн ямар цагт ундаалж байна вэ) болон улирлын хэв маяг энэ нь зүйлүүдийн хооронд хэрхэн ялгаатай байгааг судалж байна. Түүнчлэн мониторинг судалгаа нь нөөц газрын хэмжээнд хийгдэж байгаа тул бид зарим ховор амьтад тухайлбал мийн овгийн зүйлүүдийг баримтжуулна гэж итгэж байна. Мөн камерт өртсөн чоныг бодгаль тус бүрээр нь ялгах замаар Степной нөөц газрын чонын сүргийн талаар илүү ойлголтой болж байна. Эдгээр зургуудын тусламжтай бөхөнгийн орон зайн байршил нь задгай уснаас хир хамааралтай болох талаар илүү өргөн хүрээтэй мэдлэгийг бий болгоход чухал ач холбогдолтой. Эхний багц зургуудаас харахад зарим жижиг задгай ус дээр ганц нэг чоно, үнэг тэмдэглэгдсэн төдийгүй бөхөнгийн сүргийн хэмжээ уст цэгүүдийн хэмжээ хүрэлцээнээс хамаардаг болох нь ажиглагдсан.


Биологийн олон янз байдлаас байдлын талаарх мэдээллээс гадна автомат камерын зургуудын

нэмэлт мэдээллийн тусламжтай ургамлын ургалт болон температур улирлаас хамаарч хэрхэн өөрчлөгдөж буйг мөн хянах боломжтой. Уур амьсгалын өөрчлөлт зэрэг аюул заналтай холбоотойгоор амьдрах орчны бусад параметруудийг бүртгэж байгаа бөгөөд эдгээр нь бөхөнгийн шилжилт хөдөлгөөнд хэрхэн нөлөөлж буйг тогтоох боломжийг олгоно.

Төслийн хүрээнд бид Степной байгалийн нөөц газар орчимд амьдардаг нутгийн хүмүүсийн оролцоог мөн нэмэгдүүлж байна. 2019 оны 9 дүгээр сард «Возрождение» зэрлэг амьтдыг хамгаалах клубийн хүүхдүүд Степной нөөц газарт анх удаа зочилсон юм. Аяллын үеэр хүүхдүүд бөхөнг байгаль дээр ажиглах боломж бүрдсэн төдийгүй нөөц газар хийгдэж буй судалгаа шинжилгээний ажилтай танилцсан. Түүнчлэн хүүхдүүдэд судалгааны багаж төхөөрөмжийг танилцуулж, Степной нөөц газарт авсан бөхөн болон бусад зэрлэг амьтад тухайлбал үнэг, чонын зургийг сонирхуулсан. Энэхүү аяллын зорилго нь залуу судлаачдад урам зориг өгөх, мөн иргэдэд түшиглэсэн шинжлэх ухааны хүрээнд зэрлэг амьтдын мониторинг судалгаанд оролцох боломж олгоход чиглэсэн. Эцэст нь тэд задгай усанд орж байгаа томоохон бөхөнгийн сүргийг дурангаар ажигласан.

“Степ клубын гишүүн 17 настай Маша Порохни-на аяллын товч тэмдэглэлдээ “Нөөц газарт хүрэлцэн ирэхэд биднийг маш дотноор угтан авлаа. Биднийг ийм халуун дотноор хүлээн авсны дараа нөөц газрын дарга, ажилтнууд ямар гайхалтай

Мэдээний булан: үргэлжлэл



Задгай усан дээрх үнэг. Зургийг Степной байгалийн нөөц газар автомат камерын зураг.



Задгай усан дээрх бие гүйцсэн чоно. Энэ бодгаль автомат камерт хэд хэдэн удаа бүртгэгдсэн. Зургийг Степной байгалийн нөөц газар автомат камерын зураг.

хүмүүс вэ гэсэн сэтгэгдэл бидэнд төрсөн. Цай ууж завсарласны дараа бид тэртээ хол бэлчих бөхөнг дурангаар харахаар явлаа. Бөхөнг ойроос харахад маш гайхалтай байсан. Хээрийн бүргэд болон өөр ховор шувууд мөн тэнгэрт халин нисэж байлаа. Энэхүү аяллын ачаар бидний ойлголт, мэдлэг улам бүр нэмэгдэж, ховордсон амьтдын талаар шинэ, сонирхолтой баримтуудыг мэдэж, олон зэрэг ойлголттой болсон. Уг аялал хүүхэд бүрд таалагдсан!” гэж бичсэн байна.

Энэ төсөл 2020 он хүртэл үргэлжлэх бөгөөд үр дүнг нь бид удахгүй нийтлэх болно. Хэрэв та судалгаанд хамрагдах сонирхолтой бол Instant Wild дээрх

Степной нөөц газрын хуудсанд зочлох (<https://instantwild.zsl.org/projects/stepnoi-surveillance>); буюу babette971@hotmail.com. холбогдож сонирхсон асуултандаа хариулт авч болно. Энэ судалгааг Степной нөөцийн газрын хамт олон ялангуяа захирал Владимир Калмыков, Боловсролын газрын дарга Галина Калмыкова нарын оролцоогүйгээр хийх боломжгүй байлаа. Мэдээлэл сургалтын зорилготой энэ аяллыг зохион байгуулж өгсөн Ольга Воронцевад талархал илэрхийлье.



“Степной” нөөцийн газрын ажилтнууд болон “Возрождение” клубын хүүхдүүд. Зургийг Ольга Воронцева

Хэвлэлийн мэдээ


Казакстан дахь бөхөнгийн эврийн хууль бус худалдааны сүлжээг илрүүлэн, таслан зогсоолоо

Хулгайн антай тэмцэх ажлын хүрээнд Казахстан улсын Үндэсний аюулгүй байдлын хороо 2019 оны 9 дүгээр сараас 10 дугаар сард Атырау, Актөбе, Баруун Казахстан, Туркистан, Кызылордын бүс нутагт, мөн Алмата болон Шымкент хотуудад хэд хэдэн томоохон арга хэмжээ зохион байгуулав. Эдгээр арга хэмжээний зорилго нь олон жилийн турш бөхөнгийн эвэр болон эд эрхтэнг Хятад руу хууль бусаар гаргадаг зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн юм. Энэхүү ажиллагааны үр дүнд Алматы мужид гэмт хэргийн томоохон бүлэглэлийг илрүүлсэн бөгөөд уг бүлэглэл доод тал нь 3,000 орчим бөхөн хулгайгаар агнасан байна. Аюулгүй байдлын албаныхан 18 хүнийг саатуулж 1,118 кг бөхөнгийн эврийг хураан авсан. Мэргэжилтнүүдийн тооцоогоор гэмт бүлэглэл байгаль орчинд 664.6 сая тенге (14 сая доллар давсан)-ийн хохирол учруулсан байна. Гэмт этгээдүүдийн 9-ийг саатуулан хорьсон. Энэ хэрэгт Казахстан улсын Эрүүгийн хуулийн дагуу “Зохион байгуулалттай гэмт хэрэг”, “Ховордсон ургамал, амьтны төрөл зүйл, тэдгээрийн хэсэг, эд эрхтэнг хууль бусаар худалдаалсан” гэсэн зүйл ангиар эрүү үүсгэн шалгаж байна.

Байгаль орчны яамны мэдээлснээр 2019 он гарснаас хойш Казахстан улсад нийт 6,000 гаруй хүнийг хууль бус агнуурын хэргээр саатуулжээ. Гэсэн хэдий ч тэдний зөвхөн 48-д хариуцлага хүлээлгэн хорьж

Украин улс Хятад руу бөхөн экспортлох болжээ

БНХАУ-ын Шенжен Танфарма эмийн компани Украины Херсон мужийн Камыш тосгоны ойролцоо 97 га газрыг бөхөнг үржүүлэх зорилгоор 7 жилийн хугацаатай түрээсэлсэн байна. Тэд уг үржүүлгийн төвд зориулж 10 сая гаруй гривен (43,383 ам.доллар)-ий өртөг бүхий хашаа барьсан. 2018 онд уг төвд зориулан 23 бөхөнг Аскания Нова Байгалийн нөөц газраас худалдаж авсан. 2019 оны хавар зарим шаргачин төллөж тус газрын нийт бөхөнгийн тоо 34 болжээ. Тус төв бөхөн гаршуулан үржүүлж байгаа Аскания Нова нөөц газраас дахин 70 гаруй бөхөнг худалдаж авахаар ажиллаж байна. Хятадын хөрөнгө оруулагчид 70 бөхөн янзага худалдан авахад зориулж 1 сая гаруй гривен (4,338 ам.доллар) төлсөн байна. Аскания Нова нөөц газрын захирал Виктор Гавриленкогийн хэлснээр энэ мөнгийг автомашины түлш, сэлбэг хэрэгсэл, амьтдын тэжээл худалдан авахад зарцуулах юм байна.



Хураагдсан бөхөнгийн эвэр. Зургийг Өнөөдрийн Казакстан сонин

шийтгэсэн байна.

Харин бусад сэжигтнүүд хэдэн арван сая тенгегийн торгууль төлөн суллагдсан байна. Казахстан улсын Ерөнхийлөгч Касым Жомарт Токаев бөхөнгийн хулгайн анг бүрмөсөн арилгах тушаал гаргасан байна. Тэрээр “хулгайн анчид бидний байгалийн өв болсон бөхөнг агнасан хэвээр байна. Тэд хуулийн дагуу хатуу шийтгэл хүлээх ёстой. Хууль сахиулах байгууллагууд энэ хууль бус үйлдлийг таслан зогсоох ёстой” гэсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээлэлийг эндээс үзнэ үү https://www.kt.kz/rus/ecology/zaderzhano_18_chlenov_opg_zanimavsheysya_otstrelom_saygi_dlya_1377890560.html, <https://www.ktk.kz/ru/news/video/2019/10/28/132761/>

Хятадын талын хэлснээр бөхөнгийн арьс болон эвэр магадгүй урт хугацаандаа амьд бөхөнг Хятад руу экспортлохоор төлөвлөж байна. Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийг бусад түүхий эдтэй хослуулан олон төрлийн өвчнийг эмчлэхэд ашиглаж болно гэж үздэг.

Украин болон Хятад улс бөхөн болон тэдгээрийн эд эрхтнийг хуулийн дагуу экспортлоход шаарддаг мал эмнэлгийн гэрчилгээтэй болох санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү мэдээлэл Украины хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн албаны вэбсайтад тавигдсан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://kherson-news.info/main-news/kitaiskaia-ferma-po-razvedeniю-saiga-kov-popolnilas-novymi-jivotnymi/?fbclid=IwAR20-F1dyJwSNB7eFtWFrLJYtXnwjcu9yiEF71iSGZP-CO3-az2AffWiNE8A> болон https://www.dialog.ua/business/193121_1572026409 хуудаснаас үзнэ үү.

Өгүүлэл, нийтэл

2019 оны агаарын тооллогоор Казахстаны бөхөнгийн тоо толгой огцом өссөн үр дүн гарсан байна

Стеффен Цютер Казахстаны биологийн олон янз байдлыг хамгаалах нийгэмлэг steffen.zuther@acbk.kz

Казахстанд жил бүр зохион байгуулдаг бөхөнгийн агаарын тооллогоор тус улс дахь бөхөнгийн бүх популяцийн тоо толгой өссөн харагдаж байгаа нь түүхэн тоо толгойд хүрч өсөх нь гэсэн итгэл найдвар төрүүлж байна. Хамгийн том популяци болох Казахстаны баруун хэсэгт орших Уралд ойролцоогоор 217,000 орчим бөхөн тоологдсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 61%-иар өссөн үзүүлэлт юм. Харин 2015 онд халдварт өвчний улмаас их хэмжээгээр хорогдсон Бетпак-Далагийн популяци тасралтгүй өссөөр байгаа ба сүүлийн судалгаар 109,000 гаруй бөхөн тоологджээ (өсөлт 43%). Түүнчлэн Устюртын бөхөнгийн популяци өнгөрсөн жилийнхээс мөн 60 гаруй хувиар өсч 5,900 толгойд хүрсэн нь мөн адил найдлага төрүүлж байна.

Тооллого судалгааг «Охотзоопром» төрийн өмчит байгууллагын захиалгаар Казахстаны Экологи, геологи, байгалийн нөөцийн яам (хуучнаар Хөдөө аж ахуйн яам)-ны Ойн болон ан амьтан хамгаалах хорооны шийдвэрийн дагуу 2019 оны 4-р сарын 20-



Урал дахь бөхөнгийн сүргийг нисдэг тэрэгнээс авсан зураг. Энэ зураг нь бөхөнг нүдээр тоолж популяцийн тоог нарийн гаргахад хир төвөгтэй болохыг харуулж байна.

оос 5-р сарын 4-ний хооронд хийж гүйцэтгэсэн. Казахстаны Биологийн олон янз байдлыг хамгаалах холбоо уг судалгааны ажлыг гардан гүйцэтгэсэн.

Оройтож эхэлсэн бөхөнгийн тооллого судалгааг хугацаанд нь амжуулахын тулд гурван багт хуваагдан Еврокоптер EC-145 нисдэг тэргээр 200 гаруй цагийн нислэг үйлдэн гүйцэтгэсэн. Судалгаа эхлэхээс өмнө багийн бүх гишүүдэд сургалт явуулсан бөгөөд сургалтандаа тэмдэгжүүлсэн тооллогын зурвасыг ашигласан. Мөн төлөвлөлтийн хурлыг өдөр бүр хийсэн.

Казахстаны баруун хэсгийн бөхөнгийн популяцийн судалгаа хожимдож эхэлсэн нь тооллогод хүндрэл учруулсан. Учир нь 5-р сард төллөх хугацаа нь ойртох үеэр бөхөнгүүд томоохон сүргүүд үүсгэдэг. Энэ байдал тооллого эхлэх үед хэдийн эхэлсэн байсан. Их хэмжээгээр сүрэлгэсэн үед бөхөнг нүдээр нарийн тоолох боломжгүй. Тиймээс тодорхой давтамжтай тасралтгүй авсан гэрэл зургууд тооллогын мэдээг дахин нягтлахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн, бөхөнгийн сүрэг хил даван ОХУ руу нүүдэллэх нь Уралын бөхөнгийн тоо толгой бага гарах нөхцлийг бүрдүүлэх боломжтой. Гэсэн хэдий ч байгаль хамгаалагчдын мэдээнээс харахад Орос-Казахстаны хилийн дамнан нүүдэллэсэн тохиолдол ажиглагдаагүй байна.

Уралын бөхөнгийн тоо толгой өндөр гарсан хэд хэдэн шалтгаантай байж болно. Нэгдүгээрт, иймэрхүү томоохон популяцийг тоолоход хүндрэлтэй байдаг. 2018 онд нисдэг тэрэгнээс авсан гэрэл зургийн чанар 2019 оныхоос харьцангуй муу байсан бөгөөд энэ нь тооллогын үр дүнг бодитой гаргахад нөлөөлсөн байж болох талтай. Түүнчлэн, 2018 онд олон тооны бөхөн ОХУ руу хил даван нүүдэллэсэн байж болзошгүй. Хэдий тийм ч байгаль цаг уурын тааламжтай нөхцөл, аюул заналыг бууруулсан нөхцөлд энэхүү өсөлт биологийн хувьд боломжтой юм.

Устюртын бөхөнгийн популяцийн өсөлтийг дээрх байдлаар мөн тайлбарлаж болно. Аливаа жижиг популяцид тоо толгойн судалгаа хийхэд ихэвчлэн нарийвчлал багатай гардаг. Учир нь зарим сүргийг орхигдуулах эсвэл том сүрэг нэг бөөнөөрөө

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

тоологдох зэргээс шалтгаалж популяцийн үнэлгээ жилээс жилд хэлбэлзэл ихтэй гардаг. Гэсэн хэдий ч эдгээр өсөлтүүд нь эерэг үр дүн бөгөөд магадгүй энэ нь мөн хамгааллын ажил сайжирсантай холбоотой байж болно. Газрын болон агаарын судалгааны үр дүнгээс харахад дээрх хоёр популяцид үржил хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэхэд хангалттай тооны ооно ажиглагдсан.

Харин Бетпак-Далагийн бөхөнгийн тоо өмнөх жилийнхтэй ойролцоо байна. Өвчний улмаас их хэмжээгээр хорогдсоны дараагаас бөхөнгийн тоо толгойн өсөлт жил бүр 40-өөс дээш хувьтай байсан нь бөхөнгийн популяци бүрэн сэргэх найдвар төрүүлж байна. Үүнээс гадна байгаль хамгаалагчид үндсэн популяциас зүүн тийш тусдаа өөр нэг бөхөнгийн сүрэг тогтвортой байршиж байгааг мэдэжээ.



Бетпак-Далагийн бөхөнгийн популяцийн судалгааны баг. Зургийг Алберт Салмгареев

дээлсэн. Тиймээс агаарын тандан судалгааны үр дүн дээр 2,500 орчим бөхөнг (газар дээрх ажиглалтыг үндэслэн) нэмж тооцох боломжтой.

Монгол бөхөнгийн тоо толгойн сүүлийн үеийн мэдээ

Б. Чимэддорж¹, Б. Гантулга¹, А. Е. Файне², Е. Энхтүвшин², Б. Бүүвэйбаатар²

¹ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, ²Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Монгол дахь төлөөлөгчийн газар

Холбоо барих хаяг: Буянаа Чимэддорж chimeddorj@wwf.mn

Оршил ба аргазүй

Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*) нь Монгол орны унаган амьтан бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны улаан дансанд «устаж байгаа» гэсэн ангилалд багтдаг. Энэхүү амьтанд тулгарч буй томоохон аюул заналд хууль бус агнуур, байгаль цаг агаарын хатуу ширүүн нөхцөл, амьдрах орчны доройтол, халдварт өвчин багтана. Монгол бөхөнгийн орон зайн байршил, тоо толгойн хөдлөл зүй нөлөөлж буй байгалийн болон хүний хүчин зүйлсийг танин мэдэх нь уг амьтны хамгааллын менежментийг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.


Монгол бөхөнгийн популяцийн нягтшил болон элбэгшлийг тогтоох судалгааг 2018 оны 12 сарын 03-10-ны хооронд нийт тархац нутгийн хүрээнд гүйцэтгэв. Судалгаанд хоорондоо 10 км-ын зайтай системтэйгээр сонгон авсан 45 шугаман маршрутыг ашигласан бөгөөд судалгааг 4 баг нэгэн зэрэг хийсэн (Зураг 1). Хээрийн судалгаанд хамрагдсан

нийт талбай 29,012 км² бөгөөд судалгааны шугаман замналуудын урт харилцан адилгүй (5-99 км-ийн хооронд хэлбэлзэнэ) ба нийт урт нь 1,887 км байсан. Судалгааны багт Говь-Алтай болон Ховд аймгийн байгаль хамгаалагч, байцаагчдаас гадна Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, ДБХС-гийн судлаачид орж ажилласан. Хээрийн судалгааны өгөгдлийг Distance 7.2 программ (Thomas et al. 2010)-ын тусламжтайгаар боловсруулан бөхөнгийн нягтшил болон элбэгшлийн үнэлгээг гаргасан. Судалгааны явцад тэмдэглэгдсэн илэрцийн магадлалыг тооцоходоо Buckland нар (2001)-ын аргачлалын дагуу ялгаатай загваруудыг туршиж үзсэн.

Үр дүн ба дүгнэлт

Хээрийн судалгааны үеэр 50 сүрэгт хамаарах 886 толгой бөхөн ажиглаж зохих өгөгдлийг цуглуулсан. Бөхөнгийн сүрэг бөхөнгийн бодгалийн тоо дунджаар (\pm SD) 17.7 ± 20.7 амьтан байсан сүргийн тоо нэгээс 113 бодгалийн хооронд хэлбэлзэж бай-

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл




Зураг 1. 2018 оны 12-р сарын 2-8-ны хооронд хийгдсэн судалгааны үеэр ажиглагдсан бөхөнгийн сүргийн байршил

сан. Шулуун замналын дагуу өвчтэй эсвэл үхсэн бөхөн тааралдаагүй.

Судалгааны өгөгдөлд анализ хийн үзэхэд замналын дагуу бөхөн илрүүлэх магадлал 0.45 (95% CI = 0.30 – 0.66; Зураг 2) байсан бол шугаман замналын дагуу өгөгдөл цуглуулсан зурвасын өргөн дунджаар 496 м (95% CI = 355–734 м) байна. Бөхөн тархсан 29,000 км² газар нутагт 2018 оны 12-р сарын байдлаар 1 км² талбайд 0.22 (SE = 0.06) бодгаль ноогдох нягтшил бүхий нийт 6,411 бөхөн (95% CI = 3,689–11,142, CV = 28.5%) байна. Нягтшилын вариацид нөлөөлөх хүчин зүйлсийг ихээх нь бага руу эрэмбэлж үзэхэд илрүүлэх магадлал 38%, сүргийн хэмжээ 32%, бөхөн тааралдах эрчим 31% -ийг тус тус эзэлж байна.

Судалгааны үрд дүнг 2018 оны 4-р сартай харьцуулахад бөхөнгийн тоо толгой 20 орчим хувиар өссөн дүн гарч байна (5,142 бодгаль; Pruvot нар, 2019). 2018 оны зун гантай байсан учраас ирж буй өвөл бөхөнгийн хувьд хүндхэн байх төлөвтэй байна. Тиймээс бөхөнгийн тооллогыг хаврын улиралд дахин хийх шаардлагатай бөгөөд ингэснээр өвлийн улиралд бөхөн хир хорогдсоныг мэдэх боломжтой. Энэхүү судалгааны тодорхой хэсгийг “Моррис Амьтны Сан”-гийн тэтгэлгээр санхүүжүүлэв.

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл



Зураг 2. 2018 оны 12-р сарын судалгааны өгөгдөл дээр суурилан тооцсон бөхөн илрүүлэх магадлалын функц

Сингапур дахь бөхөнгийн эвэр хэрэглэгчдийн онцлог, сэдэл, худалдан авах зан төрх

Хантер Доугти¹, Диого Вериссимо^{1,2}, Регина Чун Ши Тан³, Жанис Сер Хуа Лээ³, Роман Л. Карраско⁴, Катрин Оливер⁵, Е.Ж. Милнер-Гулланд¹

¹Оксфордын их сургуулийн Амьтан судлалын тэнхим; ²Сан Диего амьтны хүрээлэнгийн байгаль хамгаалах судалгааны төв; ³Азийн хүрээлэн буй орчны сургууль, Сингапурын Нанян Технологийн Их сургууль; ⁴Сингапурын Үндэсний Их Сургуулийн Биологийн шинжлэх ухааны тэнхим; ⁵Нийгмийн эрүүл мэнд, бодлогын факультет, Лондоны эрүүл ахуй, халуун орны анагаах ухааны сургууль

Холбоо барих хаяг: Хантер Доугти hunter.doughty@zoo.ox.ac.uk

Оршил

Бөхөнгийн эвэр үндсэндээ Хятадын уламжлалт эмчилгээнд хэрэглэгддэг ихэвчлэн халуун бууруулах (Хятадын уламжлалт эмчилгээ, эмгэг, хамрын битүүрэх, хоолойн өвчин зэрэгт)-ийг эмчлэхэд хэрэглэдэг. Сингапурыг бөхөнгийн эвэр өргөн хэрэглэдэг улс гэж хүлээн зөвшөөрдөг (CITES 2018). Бөхөнгийн эвэр нь ихэнхдээ Линг Янг (羚羊) (Зураг 1) эсвэл гөрөөсний эвэр гэх мэт нэрээр зах зээлд авдаг байна. Заримдаа Татар бөхөнгийн эвэр «*Cornu Saiga tataricae*»-ийг эмийн найрла-

гад оруулдаг байна (зураг 2). Эм бэлтгэх нийтлэг сонгодог орц нь арвайн ус, хризантем цай, далан хальс, ямааны эвэр юм. 2017 оны 6-7-р сард Сингапурт бөхөнгийн эврийг юунд хэрэглэж байгаа, хэрэглээний хандлага, шалтгааныг тогтоох зорилгоор Хятад, Сингапур улсуудын 2294 хүн амын дунд хэрэглэгчийн судалгаа явуулсан.

Аргазүй

Хятадын Сингапурчууд уламжлалт эмчилгээний хамгийн том хэрэглэгчид (Lim et al. 2005) тул бид

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл



Зураг 1. Бөхөнгийн эвэр болгон зарж борлуулдаг, Сингапурын Хятадын уламжлалт эмийн бүтээгдэхүүний дэлгүүрт зарагддаг. Зургийг: Хантер Даоти

тэдэн дээр судалгаагаа төвлөрүүлсэн. Судалгаагаа Хятадын Засгийн газраас төлөвлөж өгсөн хамгийн их Хятад, Сингапурчууд амьдардаг бүсийг сонгон явуулсан. Судалгааны бүс нутгийн нийгэм, эдийн засгийн янз бүрийн түвшнийг тогтоох зорилгоор тусгайлан сонгосон бөгөөд долоо хоногийн өдөр, өдрийн цагаар уг судалгааг явуулсан. Судалгаанд оролцогчид бүгд 18 ба түүнээс дээш насных бөгөөд бид насны ангилал, хүйс, нийгэм, эдийн засгийн түвшинд тэнцвэртэй байх зарчмыг баримталсан. Судлаачид Нанян Технологийн Их сургуулийн таних тэмдэгтэй цамц өмссөн байв.

Бид хэт нэг талыг барихгүйгээр төвийг сахисан/дундыг баримтлах аргыг чухалчилсан ба энд нийгмийн хэт туйлшрахаас зайлсхийхийг ч мөн хамааруулсан. Жишээлбэл: (Нийгмийн хүсэл, тухайлбал, хариулт өгч буй хүнээс авах хариултаас хамааруулан бөхөнгийн эврийн хэрэглээг нэмэгдүүлэх) эсэхийг мөн сонирхсон. Судалгаа авахдаа бөхөн гэж дурдахгүйгээр халуун бууруулахад ямар уламжлалт эм эмчилгээ хэрэглэдэг болохыг тодруулсан. Асуултуудыг боловсруулахдаа ч нэг хариултыг авч нөгөөд оруулахгүй байхаар боловсруулсан. Статистикийн шинжилгээний хувьд ерөнхий шугаман регрессийн ялгааг харуулсан Z тестийн шинжилгээ, мөн Pearson-ийн хараат бус байдлын CHI квадратын аргыг ашигласан болно. Энэ судалгааг Сингапурын Нанянгийн технологийн их сургууль,

Нэгдсэн Вант улсын Оксфордын их сургуулийн ёс зүйн хороо баталсан юм.

Үр дүн

Судалгаанд оролцсон хүмүүсийн 438 (19%) нь бөхөнгийн эвэр нь өөрсдийгөө болон / эсвэл бусад халуурах, халууны өвчнийг эмчлэхэд ихэвчлэн ашигладаг бүтээгдэхүүн гэж мэдэгджээ. Үүнээс гадна бөхөнгийн эврийг өөрсдөө худалдаж авдаг хувь хүмүүсийн 47 хувь нь үүнийг өөр хүнд дамжуулан худалдаалдаг байна.


Бөхөнгийн эвэр хэрэглэгчид голдуу 36–59 настай, Буддист эсвэл Таоист шашинтай иргэд байлаа.

Тэнд 36-аас доош насны хүмүүс маш бага байв.

Бид бөхөнгийн эвэр ашиглалтын хувьд боловсрол ба орлогын түвшин түүнчлэн эвэр ашиглах хэмжээ 2-н хооронд ямар нэгэн хамаарал тодорхойлогдоогүй. Энэ нь бид нийгэм - эдийн засгийн судалгааны анхан шатны түвшинд бөхөнгийн эвэр хэрэглэгчдийн судалгаанд хамрагдсантай холбоотой.

Эмэгтэйчүүд болон Буддист, Таоист шашинтай дунд насны хүмүүс бөхөнгийн эврийг худалдан авах бусдад дамжуулан худалдаалах магадлал өндөр байна.

Бөхөнгийн эвэр нь бүхэл бүтэн эвэр, эврийг хусаж



Зураг 2. Бөхөнгийн эвэр агуулсан эм ("Cornu Saigae Tataricae" нэртэй), Сингапурын уламжлалт эмчилгээний дэлгүүрт зарагддаг. Зургийг: Хантер Даоти

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

хэлбэржүүлсэн хэлбэрээр, эврийн найрлагатай ундаагаар нь уух эсвэл эм хэлбэрээр зарагддаг (Зураг 1-4).

Бөхөнгийн эврийн найрлагатай ундаа (нэг төрлийн сэрүүцүүлэх ус) нь ихэвчлэн хөргөсөн хэлбэртэй байдаг бөгөөд энэ нь бүтээгдэхүүнийг өөрсдийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан хүмүүсийн 54% нь таалагдсан байна.

Сэрүүцүүлэгч ус хэрэглэгчид ихэвчлэн эрчүүд байна. Бөхөнгийн эврийн үртэс нь бүтээгдэхүүн бэлтгэх уламжлалт арга бөгөөд ахуйн нөхцөлд тусгай бэлтгэл шаардана.

Энэ аргыг хэрэглэсэн хүмүүсийн 33 хувьд таалагдсан бөгөөд энэ хүмүүс дундаж насны эсвэл эмэгтэй хүмүүс байсан.

Бөхөнгийн эвэр хэрэглэдэг хүмүүсээс яагаад ашигладаг вэ гэхэд (42%) “Энэ үйлчилдэг” мөн (29%) нь “Өөр хүн надад зөвлөсөн” гэжээ. Эдгээр шалтгааныг бусад шалтгаанаас илүү олон удаа хэлсэн. Бөхөнг тэдэнд санал болгосон хүмүүсийн (56%) «гэр бүл» эсвэл (23%) Уламжлалт эм эмчилгээний дэлгүүрийн ажилтан гэж хариулжээ.

Уламжлалт эм эмчилгээний гэр бүлийн дэлгүүрийн (46%) болон Уламжлалт эм эмчилгээний сүлжээ дэлгүүрийн (43%) бөхөнгийн эврийг өөртөө худалдаж авахаар мэдээлсэн эхний хоёр цэг байв. Бөхөнгийн эврийг онлайнар худалдаж аваагүй бөгөөд үнэндээ халуурах эсвэл халуунд эмчлэх зорилгоор онлайнар худалдан авалт хийсэн тухай 12 мэдээ байсан. Бөхөнгийн эвэр хэрэглэгч хүмүүс бөхөнг зэрлэг байгальд байдаг түгээмэл амьтан гэж боддог нь эвэр хэрэглэдэггүй хүмүүсээс харьцангуй их байсан.

Бодлогын нөлөө

Бөхөнгийн эврийн хамгийн гол хэрэглэгч хүмүүс бол дунд насны Буддист эсвэл Таоист шашинтай Хятад, Сингапурчууд байсан боловч бөхөнгийн эврийн хэрэглээ бараг бүх хүн ам зүйн бүлэгт ажиглагдсан. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хариултаас харахад бөхөнгийн эврийг хэрэглэгчдийн зөвхөн 19% нь тогтмол хэрэглэдэг гэсэн боловч үүнээс их байгаа гэдэгт бид итгэлтэй байна. Сингапурт амьдардаг 2.9 сая хятад үндэстний ижил төстэй хэсэг нь бөхөнгийн эврийг байнга худалдаж авдаг эсвэл хэрэглэдэг байх маш их боломжтой (Сингапурын Статистикийн хэлтэс 2017). Хятад



Зураг 3. Бөхөнгийн эвэр агуулсан урьдчилан бэлтгэсэн ундаа нь Сингапурын Уламжлалт эм эмчилгээний дэлгүүрт зарагдаж байсан. Зургийг: Хантер Даоти

болон Сингапурын оршин суугч бус хүмүүсийн дунд бөхөнгийн эвэр хэрэглэдэг хүмүүс ч бас байна. Жилд хэрэглэдэг эврийн тоог гаргах амаргүй учир нь бэлдмэлд хэдэн хувь бөхөнгийн эвэр ордог болохыг мэдэх боломжгүй. Энэ хэмжээ харьцангуй бага байх магадлалтай боловч бүтээгдэхүүний төрөл, дэлгүүрүүд хооронд харилцан адилгүй байна. Бөхөнгийн эврийн орцтой гэж зарагддаг зарим бүтээгдэхүүн бөхөнгийн эвэр агуулаагүй байдаг гэж яригддаг хэдий ч одоогоор тодорхойгүй байна. Энэхүү судалгаа Сингапурт бөхөнгийн эврийн хэрэглээ нэлээд өргөн цар хүрээтэй, тийм ч бага биш болохыг харуулж байна.

Энэ нийтлэлийн бүрэн эхийг харах: <https://doi.org/10.1371/journal.pone.0222038>



Зураг 4. Бөхөнгийн эврийг Сингапурын уламжлалт эм эмчилгээний дэлгүүрт зарж байна. Зургийг: Хантер Даоти

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

Дрон ашиглан баруун хойт Каспийн тэнгисийн орчмын бөхөнгийн тоог толгойг тооцов

Д. В. Добринин¹, О. В. Сухова¹

¹Далайн судалгааны төв, Москвагийн улсын их сургууль, ²Байгалийн ухааны хүрээлэн, Пермийн улсын үндэсний судалгааны их сургууль

Холбоо барих зохиогч: Дмитрий Добринин ddobrynin@yandex.ru

2019 оны 6-р сарын хоёрдугаар хагаст бид Черные земли, Меклектинскийн нөөц газар (Халимаг), Степнойн байгалийн нөөцөд (Астрахань муж) гэсэн газруудад бөхөнгийн тоо, толгойг дрон ашиглан тооцов. Үүнээс өмнө, 2018 оны 9 дүгээр сар болон 2019 оны 1 дүгээр сард бид ДБХС-гийн ОХУ дахь Хөтөлбөрийн газар ОХУ-ын Биологийн олон янз байдлыг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Степнойн байгалийн нөөц газарт тооцооллын аргачлалыг туршиж үзсэн.

Дроноос авсан видео, гэрэл зураг бөхөнг сайн таньж илрүүлж байснаас гадна тэдний хүйс, насыг ялгаж болохыг туршилтаар тогтоосон. Тооцооллын үед алдааг багасгахын тулд дроны хөдөлгөөн маневралтыг сайжруулсан. Энэхүү туршилт нь газар дээр ба агаарт байгаа дрон нь бөхөнгийн зан төрхөд хэрхэн нөлөөлж байгааг ойлгоход тустай байсан. Туршилтын үр дүнд үндэслэн судалгааны баг дрон төрлийг сонгон, хурдтай зураг авалт ба видео бичлэг хийх тохиромжтой байдлыг том газар нутгийн хүрээнд нягт, сийрэг янз бүрийн популяциудын хувьд тус бүр тогтоосон болно.



Судалгааны дрон нисгэхэд бэлтгэж байгаа нь (Меклектинскийн байгалийн нөөц газар). Зургийг: Дмитрий Добринин

Дронууд нийтдээ 1300 км хүртэл зайг туулан мэдээлэл цуглуулсан.

Хамгийн нарийвчлалтай судалгаанууд өндөр нягттай бөхөнгийн сүргүүд усны эх үүсвэрийн ойролцоо ялангуяа усан сан, хужир мараа бүхий устай газрууд, задгай ус, усны суваг далангууд дагаж бөөгнөрсөн байгааг тогтоосон Бусад газруудад сонгон судалгаа буюу трансектийн дагуу видео мониторинг хийх замаар судалгаа хийгдсэн.

Хамгийн онцгой анхаарал хандуулсан хэсэг нь дроны дуу чимээг бөхөн судлах явцад, ялангуяа олон тооны амьтан (хэдэн мянган тоо толгой) цугларсан газруудад бууруулахад чиглэсэн.

Энэ асуудлыг судлахын тулд газраас 500, 400, 350 метрийн ялгаатай өндөрт туршилтын нислэг хийжээ. Дронууд нь бөхөнгийн байдалд түгшүүрийн шинж тэмдэг илрүүлэх ажиглалт судалгаа хийж байсан бол мэргэжилтнүүд яг тухайн цаг хугацаанд зэрэгцэн газрын доорх нуувчнаас бөхөнгийн зан төрхийн ажиглалт явуулсан.

Энэхүү янз бүрийн өндрөөс авсан судалгааны үр дүнгээс үзэхэд бөхөнгийн сүргийн / тайван байдлыг нь алдагдуулахгүйгээр /айлгаж үргээхгүй/ зураг мэдээлэл цуглуулж чадвал элбэгшил, тархалт, хүйс, насны бүтэц, бусад идэвхийн тухайд бүрэн/мэдээлэл олж авах боломжтой нь тогтоогдсон. 400 м өндрөөс зураг авах нь харьцангуй өргөн газар нутгийг хамарч нэг даралтаар нарийвчлал сайтай зураг авахад хамгийн тохиромжтойг тогтоосон.

Судалгааны ажлыг төлөвлөхдөө судалгааны зам чиглэлийг дээр дурдсан хамгаалалттай газар нутгийн мэргэжилтнүүдтэй хамтарсан хэлэлцүүлэг хийж зөвлөлдсөн. Судалгааны үеэр Степнойн байгалийн нөөц газрын байгаль хамгаалагчид газар дахь нуувч болон ажиглалтын өндөр цамхгаас нэгэн зэрэг судалгаа явуулан гэрэл зураг авч то

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл



Зураг 1. Степнойн байгалийн нөөц газарт хийсэн агаараас бөхөнгийн зураг авалтын хэсэг.

оллого хийж байлаа. Эдгээр мэдээллийг дараа нь дрoноос авсан мэдээлэлтэй харьцуулан тааруулж үр дүн нь ландшафтын онцлог, амьтдын нас, хүйс, зан төлөв зэрэг үзүүлэлтүүд дээр суурилан тодорхойлогддог.

Судалгааны дараа нэн даруй дижитал гэрэл зураг, видео материалыг боловсруулж, бөхөнгийн тархац, хүйс, насыг тогтоосон. Материалыг бие даан ажилладаг шинжээчдийн бүлэг боловсруулсан.

Ялангуяа хэвтэх, зогсож, хөдлөх (хурдан, дунд, удаан) гэх мэт өөр өөр төрлийн үйл ажиллагааг ангилах аргыг боловсруулахад онцгой ач холбогдолтой байлаа. Бөхөнгийн эр, эм, бие гүйцсэн ба залуу бодгалиудыг ялгах, нас хүйсийг тогтоох тодорхойлохын тулд тэдний зан төрхийн хэлбэр төрлүүд түүний байнга ажиглагддаг байрлал зэрэг үзүүлэлтүүдийг нь ашиглан боловсруулсан.

Хамгийн чухал нь үндсэн газар нутгийн хүрээнд амьтдын тархалтыг ижил цаг хугацаанд цаг агаа-

рын ижил төстэй нөхцөлд богино хугацаанд бүртгэсэн. 6 дугаар сарын 19-ээс 25-ны хооронд өдөр тутмын өндөр температур нь 370C байсан нөхцөлд их хэмжээний бөхөн урсгал задгай ус, түр зуурын усан сан, хужир давстай мараа бүхий ус бүхий газраар илүү ихээрээ бөөгнөрч байсан.

Дроноор орой, шөнө, өглөө бүр дээрх усны эх үүсвэрүүдээс эргэн тойронд дөрвөн км-ийн зайд амьтдын өдөр тутмын шилжилт хөдөлгөөнийг бүртгэв.

Өдрийн цагаар бөхөн тэрхүү уст цэгүүдийн эргэн тойронд ихээр бөөгнөрч төвлөрсөн байв. 6-р сарын 19, 20, 25-ны өдрүүдэд Степной дахь томоохон задгай ус бүхий газрын ойролцоо ихээр бөөгнөрсөн нь дроны зургаар тогтоогдов.

Нийт нөөц 4,003, 4,060 ба 3,894 байв. Харин 6-р сарын 25-ны өдөр цөөн тооны бөхөн урд зүгт 7 км зайтай орших жижиг задгай уснууд руу очсон байлаа. Энэ өдөр ажиглагчид жижиг худгийн ойрол-

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

цоо 100 орчим тоо толгой бүртгэсэн бол 6-р сарын 19, 20-нд дрон 12 хүртэлх бөхөнгийн зургийг авчээ.

Степной байгалийн нөөц газрын том хэмжээний задгай усны ойр орчимд төвлөрсөн бөхөнгийн тоо толгойн бүртгэлд хийсэн дүн шинжилгээ /Зургийн нарийвчлал (зураг 1).

Дөрвөн шинжээчдийн бие даасан тооллогуудын хоорондох хамгийн их зөрүү нь долоон толгой байсан бөгөөд нийт тооллын дунджаар 4060 тооны бөхөн тогтоогдсон байна.

Энэхүү стратеги нь алдааг багасгахын тулд бөхөн 5-10 км-ээс илүү шилжиж хөдлөхөөс өмнө богино хугацаанд орон зайн тархалтыг бүртгэн бичиж авах явдал.

Энэхүү хосолсон судалгаагаар видео бичлэгийн болон гэрэл зургийн аппаратаа, дроны далавчинд суурилуулсан тоногдсон нэг дроныг ашигласан. Дрон нисч байсан 3-5 км өргөн зурвасаар бөхөн байгаа байхгүй байгаа тухай бичлэгийн видеог камерыг операторууд хянаж байсан.

Тохируулах линзээр тоноглогдсон бол видео камер нь фото зургийн камераас хамаагүй илүү өргөн хүрээг хамарч чаддаг боловч видеонуудын чанар нь гэрэл зургаас хамаагүй доогуур байв.


Тиймээс өндөр чанарын мэдээллийг баталгаажуулахын тулд дрон нисгэгчийн дор шууд 300 м өргөнтэй газрын зурвасыг буулгаж авав.

Шууд хийсэн видео, гэрэл зураг дээрх амьтдын тоог харьцуулж экстраполяци загварыг боловсруулсан нь дрон хүрээгүй газарт бөхөнгийн тоо толгойг тооцоолоход ашиглахад тохиромжтой болно.

Судалгааны дүнд бөхөнгийн нийт тоо 5021 бүртгэгдсэн бөгөөд 573 эр (11%), 2399 эм буюу (48%), 2049 залуу бодгаль (41%) тус тус бүртгэгдсэн байлаа.

Үүнтэй ижил төстэй ажлыг бөхөнгийн орооны үед (2019 оны 11-р сараас 12-р саруудад) Каспийн тэнгисийн хойд өмнөд бүсийн хамгаалалттай газруудад тархан байрлах бөхөнгийн тоо толгой, тархалтын талаар мэдээлэл авах зорилгоор төлөвлөж байна.

Зохиогчид Степной байгалийн нөөцийн газрын удирдлага, ажилчдад энэхүү технологийг боловсруулж туршихад нь дэмжлэг үзүүлсэнд, мөн Чёрный Земли-ийн захиргааны ажилчдад гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.



Зураг 2. Дроны (зүүн) видео бичлэг ба зураг мөн газар дээрх гэрэл зургийн (баруун) камераас авсан бөхөнгийн зургуудыг харьцуулсан байдал. Чёрный Земли нөөц газар.

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

Элтон нуур: ОХУ-д шинээр байгуулагдсан шим мандлын нөөц газар, түүний бөхөн хамгаалалд гүйцэтгэх үүрэг

И. Ю. Калюзная^{1,2}, С. Е. Ауткулова², Н. С. Калюзная³

¹Елтонскийн дархан цаазат газар; ²Елтонскийн дархан цаазат газар; ³Биологийн олон янз байдлын хамгаалал ба судалгааны бүсийн төв

Холбоо барих зохиогч: Ирина Калюзная kalioujnaia@yandex.ru

Энэхүү тусгай хамгаалалттай газрын хувьд бөхөнгийн тархац нутаг бүхэлдээ хамрагдаж байгаа Бөхөнгийн мэдээ №22 (2017)-д мэдээлсэн. Түүнчлэн энд ОХУ-ын (Астрахан, Волгоград, Саратовын бүс нутаг) эсвэл Казакстаны (Баруун Казакстаны бүс нутгууд) газруудад ялангуяа Волга-Уралын популяцийн хувьд бөхөнгийн популяцийн хил хязгаарыг хадгалах хамгаалалттай газар нутаг байхгүй болохыг тэмдэглэсэн байдаг.

Бидний мэдэх Элтон нуурын шим мандлын нөөц газар шинээр байгуулагдсанаар 2019 оны 6 дугаар сард Дэлхийн шим мандлын нөөц газруудын сүлжээнд орж, улмаар түүний нөхцөл байдалд ихээхэн өөрчлөлт гарсан. Өөр нэг чухал үр дүн бол шинэ хэлбэрийн ландшафт ялангуяа цөл хээрийн бүсийг энэхүү хамгаалалттай газарт хамруулан хамгаалсан нь чухал алхам болжээ.

Шим мандлын нөөц газар Элтон нуурын эргэн тойронд 207000 га талбай эзлэн орших бөгөөд давтагдашгүй өвөрмөц хужир давсархаг усан толь-сангууд ихтэй. Эдгээрийн олонх сав газрууд хээр ба цөлийн холимог ландшафт бүхий Каспийн тэнгис эсвэл Волга Уралын хагас хуурай цөлийн бүсэд хамаарагдана. Түүнчлэн энэхүү хамгаалалттай газар нь улс төрийн хувьд Орос ба Казакстаныг, байгалийн бүсийн хувьд хээр ба цөлийг, харин газарзүйн хувьд Европ болон Азийг хамарсан өргөн цар хүрээтэй тархац нутгийг хамардаг.

Энэ шим мандлын нөөц газар түүхийн хувьд ч одоо байгаа бөхөнгийн популяцийн хувьд ч тархац нутгийг бүрэн хамаарах төдийгүй маш олон амьтан ургамлын зүйлүүдийн тархац, дэлхийн хэмжээний нүүдлийн замууд, тэдгээрийн зах хязгаараар олон хэсгүүдэд хуваагдаж байдаг. XIX зууны дунд үе хүртэл бөхөн Волгоградын бүс нутаг, Волгогийн баруун эрэг ба өмнөд хэсгийг хамарсан Транс-Волго орчмын цөл хээрийн ландшафтад тархдаг байсан.

Сүүлийн 20 жилийн туршид Волгоградын бүс нутагт бөхөнгийн судалгаа огт хийгдээгүй. Хааяа нэг хийгдсэн судлаачдын бүтээл тайлангаас үзэхэд сүүлийн үед бөхөнгийн сүрэг ихэвчлэн Палловский дүүрэгийн Транс Волга орчимд тэмдэглэгдсэн бөгөөд тэд Казакстан руу нэвтрэхдээ улирал ба жилээсээ хамааран 300-1000 хүртэл тоогоор нүүдэллэдэг болохыг тогтоосон байна.

Элтон нуур, шим мандлын нөөц газрын баруун хойт хэсэг, Хараа голын дээд эх түүнтэй залгаа оршдог нуурын хойт хэсгээс цутгадаг хэсгүүд үндсэндээ бөхөн төллөх газар нутаг болдог. Гэсэн хэдий ч сүүлийн хэдэн 10 жилд энэ газрын Оросын хэсэгт бөхөн гөрөөс төллөх явдал бүртгэгдээгүй байна. 2017 оны байдлаар бөхөнг Волгоградын бүс нутгийн Улаан дансанд оруулсан байна (<https://oblkompriroda.volgograd.ru/norms/acts/krasnaya-kniga-volgogradskoy-oblasti>).

Үүний үр дүнд тухайн бүс нутгийн хэмжээнд бөхөнгийн архивлагдсан болон одоо байгаа мэдээ өгөгдөлд дүн шинжилгээ хийх, ерөнхийлөн дүгнэхийн тулд үйл ажиллагааг эхлүүлэх удирдамж гарын авлага гарчээ.

Бөхөн хамгаалал мониторингийн үйл ажиллагааг Элтоны тусгай хамгаалалттай газар нутаг хариуцан явуулж Элтон нуурын шим мандлын нөөц газрыг менежмент удирдлагаар хангаж ажилладаг. 2018 оноос тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд судалгаа, мониторинг хийх бөхөн хамгаалах үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн. Энэ хүрээнд, улсын хөтөлбөр гарч 2018-2019 онд 100 гаруй харуул байгал хамгаалагчид Элтон нуурын шим мандлын нөөц газарт ажиллаж байна.

Энэхүү судалгааны ажлын дүнд шим мандлын нөөц газар болон Хараа голын дээд татам орчмор (1-р зургаас харах) өөр өөр хэсгүүдэд бөхөнгийн

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл

сүрэг 50-5000 хүртэл /төлийг оролцуулаад/янз бүрийн хэмжээгээр сүрэглэдэг болохыг тогтоосон ба дараах газар нутгуудад бүртгэгдсэн байна. Үүнд: Улаган уулын зүүн хэсэг Карповийн ферм болон Утиная Валкагийн ойролцоо (Зураг. 4); Баякадан ба Садоваягийн үхрийн ферм үржүүлгийн ойролцоо (Зураг. 5); Калининагийн аж ахуй ба Шеркес хонины ферм орчимд (Зураг 6); Саягашу ба Полинны төмөр замын зөрлөг орчим (Зураг7). Хэсэг бөхөнгийн бүлгүүд шим мандлын нөөц газартай залгаа оршдог газруудад, тухайлбал баруун зүгт Булукта нуур ба Кодрасовын Сад орчимд, хойт зүгт Савинка ба Кумушка тосгоны ойролцоо мөн Кумушка болон Куликовын аж ахуй орчим (Палассовский дүүрэг) түүнчлэн Торгун ба Гмелинка тосгон (Старополтавски дүүрэг) тус бүр бүртгэгдсэн байна.

Палассовский дүүргийн нутгийн оршин суугчдын дунд явуулсан ярилцлагаар зэргэлдээх газар нутгуудад байгаа бөхөнгийн нүүдэл шилжилтийн зам ба тоо толгойг тогтоох боломжтой болсон. 2019 оны 4 дүгээр сард нутгийн иргэд 300-350 тоо толгой бүхий бөхөнгийн сүргийг шим мандлын нөөц газраар нэвтэр гарсныг Казакстаны (Вишневка тосгоны ойролцоо) ажигласан байна.

2019 оны намрын эхэн сар хүртэл ганц нэгээрээ амьтад болон жижиг бүлгүүд (5-аас 40 хүртэлх тоо толгойтой) нэлээд их хэмжээгээр шим мандлын нөөц шазрын зүүн хэсэгт, ихэнхдээ Венгеловка тосгон, Карповын ферм, Шеркешийн хонины аж



Транс-Волгагийн өвөгт тогорууны популяци (*Ал-thropoides virgo*) Волгоградын бүс нутгийн улаан дансанд бүртгэгдсэн, Европд өргөн тархалттай. Зургийг: Александр Попов



Megascarpea megalocarpa, Волгоградын бүс нутгийн улаан дансанд бүртгэгдсэн, Волгогийн доод хэсгээрзөвхөн Элтон ба Баскунсак давстай нуурын орчимд тохиолддог ургамал. Зургийг: Александр Попов


ахуйн ойролцоо ажиглагдаж байлаа (3, 4, 6-р цэгүүд). Эдгээр нь шим мандлын нөөц газарт бөхөнгийн үржил төллөлтийн дараа сүргээс үлдсэн амьтад байж магадгүй юм.

Бөхөнгийн мониторинг хийж эхэлснээс хойш богино хугацаанд хийсэн судалгааны үр дүнгээр нөөц газарт байгаа бөхөнгийн тоо толгойн чин хандлагын талаар бодтой дүгнэлт гаргаж зураглал хийхэд эрт байгаа. Гэсэн хэдий ч нөөц газрын хэмжээнд бөхөнгийн тохиолдлууд их бүртгэгдэж байгаа нь Волга-Уралын популяцийг бүхэлдээ өсөн нэмэгдэж байгааг шинжлэх боломжтой болж байна (өмнө үзүүлсэн С. Зутерийн өгүүллээс харах).

Нутгийн иргэд, нөөц газарт зочлогсдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор бөхөнгийн талаархи мэдээллийг Волгоград мужийн засаг захиргаа болон бүс нутгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, байгалийн нөөцийн зөвлөл, ой ба хүрээлэн буй орчны хорооны албан ёсны вэб сайтуудад нийтлэв.

2019 онд Волгоградын Байгалийн нөөц баялаг, ой ба хүрээлэн буй орчны хороо нь бөхөнг хамгаалах,

Өгүүлэл, нийтэл: үргэлжлэл



хянах, мэдээллийн цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр байгаль орчны болон боловсролын тодорхой үе шатуудтай цуврал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн. Түүний нэг нь Элтон нуурын шим мандлын нөөц газрын мэдээллийн төв байгуулах, боловсролын болон бүтээлч арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

2020 он ба түүний дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх үндэсний "Экологи" төслийн хүрээнд ОХУ-ын Байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны яамнаас Бөхөн хамгааллын зураг төслийг санал бол-

гон төлөвлөсөн:

Эндээс дүгнэхэд, бөхөнг Волгоградын бүс нутгийн Улаан дансанд оруулан, Элтон нуурын шим мандлын нөөц газрын захиргаа боломжтой хяналт мониторинг явуулж тогтмол хэмжилт хамгааллын ажлыг хэрэгжүүлснээр нөөц газрын хүрээнд төдийгүй ойролцоох нутгуудын хэмжээнд бөхөн хамгаалах судлах ажил идэвхтэй хэрэгжиж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Шинэ хэвлэгдсэн өгүүллүүд

Pruvot, M., Fine, A.E., Hollinger, C., Strindberg, S., Damdinjav, B., Buuveibaatar, B., Chimeddorj, B., Bayandonoi, G., Khishgee, B., Sandag, B. and Narmandakh, J., 2020. Outbreak of Peste des Petits Ruminants among Critically Endangered Mongolian Saiga and Other Wild Ungulates, Mongolia, 2016-2017. *Emerging infectious diseases*, 26(1), p. 51
<https://www.ncbi.nlm.nih.gov/pubmed/31855146>

Fereidouni, S., Freimanis, G.L., Orynbayev, M., Ribeca, P., Flannery, J., King, D.P., Zuther, S., Beer, M., Höper, D., Kydyrmanov, A. and Karamendin, K., 2019. Mass Die-Off of Saiga Antelopes, Kazakhstan, 2015. *Emerging infectious diseases*, 25(6), p. 1169
<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC6537709/>

Orynbayev, M., Sultankulova, K., Sansyzbay, A., Rystayeva, R., Shorayeva, K., Namet, A., Fereidouni, S., Ilgekbayeva, G., Barakbayev, K., Kopeyev, S. and Kock, R., 2019. Biological characterization of *Pasteurella multocida* present in the Saiga population. *BMC microbiology*, 19(1), p. 37
<https://bmcmicrobiol.biomedcentral.com/articles/10.1186/s12866-019-1407-9>

Giljov, A., Malashichev, Y. & Karenina, K., 2019. What do wild saiga antelopes tell us about the relative roles of the two brain hemispheres in social interactions? *Animal Cognition*, 22: 635
<https://link.springer.com/article/10.1007/s10071-019-01259-0>

Tarasyan, K. K., Sorokin, P. A., Kashinina, N. V., & Kholodova, M. V., 2019. High Allelic Diversity of the DRB3 Gene (MHC Class II) in Saiga (*Saiga tatarica* L., 1766), Obtained by Next Generation Sequencing Method. *Russian Journal of Genetics*, 55(2), 212-219
<https://link.springer.com/article/10.1134/S1022795419020133>

Robinson, S., E. J. Milner-Gulland, Y. Grachev, A. Salemgareyev, M. Orynbayev, A. Lushchekina, E. Morgan, W. Beauvais, N. Singh, S. Khomenko, R. Cammack, and R. Kock. 2019. Opportunistic bacteria and mass mortality in ungulates: lessons from an extreme event. *Ecosphere* 10(6).
<https://esajournals.onlinelibrary.wiley.com/doi/10.1002/ecs2.2671>

Мэдээ

2019 оны SCA хөтөлбөрийн жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөр болон залуу байгаль хамгаалагч хөтөлбөрийн ялагчдыг танилцуулж байна

2019 онд Бөхөн хамгаалах нийгэмлэг залуу байгаль хамгаалагч болон жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөрийг тогтсон уламжлалын дагуу зарласан.

Залуу байгаль хамгаалагчдын уралдаанд ОХУ, Казакстан, Узбекистанаас 6 өргөдлийн материал хүлээн авсан.

Айбат Музбей, 22 настай, Казакстаны Караганда хот

“Миний судалгааны ажил Ustyurt saiga бөхөнгийн популяцийн тархац нутаг дахь усны нөөц ба түүний ХАА-н хэрэглээ гэсэн сэдэвтэй. Энд тухайн бүс нутаг дахь бөхөнгийн тархац, шилжилт хөдөлгөөний мониторинг ба үнэлгээний ажил хамт хийгдэж байгаа юм. Эндээс хамгийн чухал мэдээлэл нь ХАА- идэвхтэй хэрэглээний газрууд болон худгийн байршлууд бөгөөд эдгээр нь цаашдаа зэрлэг амьтдын зохистой менежментийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой байна”.

Каундак Айкимус, 15 настай, Казакстаны Кустанайгийн Зангелди дүүрэг, Баутүрсунулу тосгон

“Миний төсөл нь зэрлэг бөхөнг харахаар манай тосгонд олноороо ирдэг жуулчид мөн тосгоны оршин суугчдад зориулан бөхөн хамгаалахад чиглэсэн мэдээлэл танилцуулах үндсэн зорилготой. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүнд зориулсан сайн мэдээлэлтэй гарын авлага хийх түүнчлэн худалдаалах зориулалтын оёмол хатгамал гар урлалын бүтээгдэхүүнүүдийг дэмжиж ажиллана”.

Бид мөн зуны бааз зохион байгуулахаар төлөвлөж байна. Жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөрийн хувьд ОХУ Казакстан, Узбекистанаас нийт 8 хүн өргөдлийн материал хүлээн авч гурвыг шалгаруулсан.

Шалгарсан төслүүдийн хувьд:

Галина Калмакова, Василий Паршин, Бабете Поурер, Ольга Воронцева, Зургийг: Степной. Байгалийн нөөц газар.



Галина Калмикова, Василий Паршин, Бабете Фюрер, Ольга Воронцева. Зургийг Степной байгалийн нөөц газар

Ольга Воронцева ба Бабете Поурер нар “Степнойн танадан судалгаа” төсөл. Оросын Степнойн байгалийн нөөц газрын үйл ажиллагааны хүрээнд бөхөнгийн мониторинг судалгааг үргэлжлүүлэн хийх зорилготой.

Мухит Суйтибай “Казакстаны хэмжээнд бөхөнгийн эвэр худалдаалах тухай интернэт орчны мэдээ мэдээллийг зогсоох” төсөл.

Александр Путин “Бетпақдалагийн бөхөнгийн популяцийн шинэ бүлгүүдийн тоо толгойн үнэлгээ” төсөл.

Бид эдгээр тэтгэлэгт төслүүд 2019 онд хэрхэн амжилттай хэрэгжсэн талаар мэдээлэл хүргэх болно. Уншигч та бүхэн 2020 оны шалгаруулалтад идэвхтэй оролцохыг урьж байна. Сонгон шалгаруулалтын тухай мэдээлэл SCA веб хуудас: saiga-conservation.org – д тавигддаг.

Мэдээ: үргэлжлэл

Доктор Юри Грачевийн 80 насны ойн баярын мэнд хүргье

Казакстаны хамгийн сайн хөхтөн судлаачдын нэг. Таны маш олон жилийн туршлага, харьцуулшгүй их бөгөөд хамгийн бодитой тайлбар толь шиг олон талт мэдлэг түүнчлэн экспедицийн нөр их түүх туршлага бүгд нийлж биологийн олон янз байдал ба тухайн амьтдын зүйлүүдийн судалгаа хамгаалал, тэдгээртэй холбоотой маш олон асуудлуудыг шийдвэрлэхэд үндсэн суурь болж байна.

Таны 80 насны ойд хүндэтгэн баяр хүргэж эрүүл энх, эрч хүчтэй байхыг хүсэн цаашид олон олон жилийг хамгийн сонирхолтой бөгөөд гайхамшигт ололт нээлтүүд хийсэн аяллуудаар дүүрэн байхыг чин сэтгэлээсээ ерөөе. **Анна Лушчекина (БХХ байгууллага)**

Хүндэт Юри, Таньд 80 насны ойн баярын мэнд хүргэж эрүүл энх сайн сайхан бас олон аз жаргалтай бөхөнгийн өдрүүдийг хүсэн ерөөе! **Алине Күүл-Штензел (БХХ байгууллага)**

Хүндэт Юри Александрович! Энэ гайхалтай ойн баярт чин сэтгэлийн халуун баяр хүргэе. Би танд эрүүл энх, үргэлжилсэн амжилтууд, аз жаргал мөн урт удаан сайн сайхан амьдрал хүсэн ерөөе. Манай дэлхийн бөхөнгийн судалгаа, хамгааллаар амжилт бүтээлтэй хамтран ажилласнаа тэмдэглэмээр байна. Таны мэдлэг чадвар болон туршлага зүйрлэхийн аргагүй. Таныг хүндэтгэсэн **Юри Аролов (БХХ удирдах зөвлөл)**

Хүндэт Юри Александрович! Би таныг маш олон жилийн өмнөөс мэднэ. Миний мэдэхээр та бол өндөр стандартын мэргэжлийн ур чадвартайгаас гадна гайхалтай хүнлэг, шинжлэх ухааны төлөө өөрийгөө зориулж чаддаг байгаль болон хүмүүст хайртай хүн билээ. Би таньд эрүүл энх, шавхагдашгүй эрч хүч бас амжилт бүтээлүүдийг хүсэн ерөөе. Хүндэтгэсэн **Елена Букова (БХХ-ны Узбекистаны хөтөлбөр, удирдах зөвлөл)**

Хүндэт Юри Александрович, та бол энэ салбартаа үнэхээрийн мэргэжлийн өндөр ур чадвартай эксперт. Та бол Казакстаны өргөн уудам нутаг дахь амьтдын тухай бүгдийг нь мэддэг гэж хэлэхэд алдаа болохгүй хүн. Та хамтран ажиллаж байгаа бүх хүмүүстээ зөвлөн туслахад үргэлж бэлэн байдаг төдийгүй өөрийн мэдлэг туршлагаа үргэлж хуваалцаж байдаг. Би таныг сэтгэлээсээ хүндэтгэн



биширч байна. Ойн баярын мэнд хүргэе. Эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе. **Александр Есипов (БХХ удирдах зөвлөл)**

Хүндэт Юри, та бол миний зүрх сэтгэлд онцгой орон зай эзэлсэн хүн учир нь. Энэ бүх он жилүүдээс өмнө та надад хамгийн анх бөхөнгийн тухай танилцуулж, Бетпак-Далагийн экспедицэд дагуулан авч явж байсан.

Би танд талархаад баршгүй учир нь ямар ч туршлагагүй, хээрийн судалгааны талаар ойлголтгүй залуу Англи судлаач оюутан Казакстанд ирж судалгаанд оролцохыг хүсэн захиа бичиж байхад дэмжиж далавчин доороо авч явсан. Намайг албан ёсоор бэлтгэн хүлээн авсанд маш их баярлалаа. Бидний виски болон архины амтыг харьцуулангаа Сир Волтер Скотт болон Лондонгийн утааны тухай талын дунд өрнүүлсэн ярианууд бас бөхөнг яаж барихыг үзүүлсэн хээр талын амьдралдаа би үнэхээр сэтгэл дүүрэн байдаг. Би таныг амьтны шинжлэх ухааны латин болон англи нэрийг (XIX зууны) надаас илүү мэддэгийг мэднэ. Таны экологийн гүнзгий мэдлэг ба экологийн судалгаа, мониторингийн

Мэдээ: үргэлжлэл

олон ярвигтай асуудлуудын доор бат зогсож чаддаг байдал чинь таны араас залгамжлан гарч ирж байгаа бөхөн судлаачид хамгаалагчдад асар их нөлөө үзүүлсээр ирсэн. Таны дотоод мөн чанар оюун ухаан тань үргэлжлэн Казакстан дахь бөхөн судлах хамгаалах санг бий болгосон.

Би тантай хамт судалгаа хийсэн он жилүүдээрээ үнэхээр бахархаж байгаагаас гадна одоо хүртэл надтай болон тан руу явуулдаг судлаачид, оюутнуудтай маань хамтран ажиллаж байгаад баярла-

лаа. Та тэднийг цаашдаа хэрхэн ажиллахыг харах болно. Таны хүлээцтэй нэр хүндтэй байдал эелдэг найрсаг зан чанар юугаар ч хэмжигдэшгүй бөгөөд зөвхөн таны шинжлэх ухааны зөвлөгөө туршлагатай л зүйрлүүлж болох юм. Төрсөн өдрийн мэнд хүргэе. Олон баяртай мэдээтэй эргэн уулзалдъя. Таны найз **Е. Ж. Милнер-Гуланд (БХХ –ны дарга)**

Бөхөнгийн баатрууд

Давид Маллон, дэлхийд хамгийн их танигдсан бөхөнгийн мэргэшсэн шинжээчдийн нэг бөгөөд IUCN – ийн туруутны мэргэжилтнүүдийн бүлгийг хамтран удирддаг, Английн Манчестерийн Метрополитон их сургуулийн Биологи ба байгаль хамгааллын биологийн тэнхимийн дэд профессор. Тэрээр Абу-Дхаби хотноо 2019 оны 10 сард болсон IUCN- SSC ийн удирдагчдын уулзалтаар СЕР ПЕТЕР СКОТТын байгаль хамгааллын гавьяат ажилтан цол хүртжээ. Энэхүү шагнал нь Давидын урт хугацааны туршид Ази Африкийн том хөхтөн амьтны хамгааллын чиглэлээр SSC-ээр дамжуулан шийдвэрлэх үр бүтээлтэй ажилласан, Туруутаны мэргэжилтнүүдийн бүлгийг хамтран удирдаж байгаа болон IUCN-ийн улаан дансны зөвлөлийн идэвхтэй оролцоо, хэд хэдэн хэл дээр хийгддэг хамгааллын төлөвлөлтийн хурлуудад оруулсан хувь нэмэр оролцоо, түүний хувь хүний ухаалаг зоримог зан чанараа ажил мэргэжилдээ хэрэглэдэг байдлыг тодорхойлж хүртээсэн байна. Бид Давидэд энэхүү нэр хүндтэй шагналыг хүртсэнд нь баяр хүргээд хэдэн асуулт асуумаар байна.



Давид Сер Петер Скоттын байгаль хамгааллын гавьяат ажилтан цол тэмдгээ аваад байна. Зургийг: Майк Найт

Редактор: Та хамгийн анх хэзээ бөхөн гэх амьтныг сонирхож эхэлсэн бэ?

Д. М.: Би 35 жилийн туршид төв Азийн хөхтөн амьтдыг сонирхон судалсаар ирлээ.

Редактор: Бөхөнгийн судалгаа болон хамгааллын чиглэлийн үйл ажиллагаа та яг хэзээнээс эхэлсэн бэ?

Д. М.: Миний хамгийн анхны оролцсон судалгаа бөхөнгийн төлөв байдал хамгаалалын талаар 1990 онд Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны улаан дансны хүрээнд дундад ба зүүн Азийн туруутны үнэлгээ хийх ажилд оролцсон явдал. Тэр үеэс эхлээд Туруутны мэргэжилтнүүдийн бүлэгт гишүүнээр ажиллаж эхэлсэн. Одоо Бөхөн хамгаа-

Мэдээ: үргэлжлэл

лах холбооны удирдах зөвлөл мөн менежментийн багтд ажилладаг.

Редактор: Та бидэнд бөхөнтэй холбоотой ямар нэг сонирхолтой түүхүүдээс ярьж өгөөч?

Д. М.: Хэдэн мянган жилийн тэртээ бөхөн Их Британид тархаж байсан нь сонирхолтой, итгэмээргүй түүх юм даа.

Редактор: Таны ажлын хувьд хамгийн гол тулгамдсан асуудал нь юу вэ?

Д. М.: Миний хийж байгаа бөхөнтэй холбоотой үйл ажиллагаанууд ерөнхийдөө Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенц (CMS), Улаан данс болон Бөхөн хамгаалах холбооны ажлын хүрээгээр хязгаарлагддаг бөгөөд яг хээрийн судалгааны төслүүд биш байдаг. Хамгийн гол тулгамдсан асуудал нь урт хугацааны туршид хамгааллын нэн шаардлагатай үйл ажиллагаануудыг бүрэн хэрэгжүүлэх санхүүжилт олох явдал юм.

Редактор: Та ажлынхаа хүрээнд саад бэрхшээлдүүдийг хэрхэн зайлуулдаг вэ?

Д. М.: Та Ямар нэгэн хамгааллын ажилд санхүүжилт олно гэдэг бол хамгийн хэцүү хэсэг бөгөөд энд ямар нэг байдлаар хялбар шийдчих боломж байдаггүй.

Редактор: Бөхөн хамгааллын төлөв байдал ямар байна вэ?

Д. М.: Тухайн зүйл амьтныг хамгаалахад бөхөн тархсан бүх улс орнууд нэгдэн орсон, бөхөн хамгаалах үйлсэд хамтарч байна. Ялангуяа 2004 оноос хойш тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах, хууль бус агнууртай тэмцэх, судалгаа шинжилгээ хийх, сургалт сурталчилгааны ажил хийх зэрэг чиглэлд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн. Эдгээр бүх асуудлууд нь Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенц (CMS)-ийн хүрээнд батлагдсан харилцан ойлголцлын санаамж бичгийн хүрээнд бөхөн хамгаалах асуудлыг дэлхий дахины асуудал болохыг тусгасан. Олон талаас нь авч үзэхэд ерөнхий төлөв байдал сайн,өвчин голомтлон тархахаас сэргийлэн хянахаас гадна ямар нэг хууль бус худалдааны асуудлуудыг хянахад үндсэндээ чиглэж байна.

Редактор: Та байгаль хамгааллын салбарт 30 гаруй жил ажиллалаа. Энэ хугацаанд юу өөрчлөгдөв бас яг одоогийн дэлхийн нийтийн чиг хандлага ямар байна вэ?

Д. М.: Хамгийн гол өөрчлөлт бол хүний нөлөөнөөс шалтгаалан байгалийн амьдрах орчин доройтож хомсдох, жижгэрэн хуваагдах, хэт ашиглалт хийх явдал нэмэгдсэн. Харин одоогийн тулгамдсан гол асуудал уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал болж байна.

Гэгээн дурсгалд зориулав

Доктор Бадамжавын Лхагвасүрэн

2019 оны 8 сарын1, Док. Б. Лхагвасүрэн, Бөхөн хамгаалах холбооны удирдах зөвлөлийн гишүүн, 60 насандаа таалал төгссөн.

Тэрээр 1981 онд Монгол улсын их сургуулийн биологийн факультетыг төгссөнөөс хойш Шинжлэх ухааны академийн Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнд ажиллаж эхэлсэн. Үүнээс 15 жилд нь хөхтний экологийн лабораторийн эрхлэгчээр ажиллажээ.

Түүний удирдлага дор хөхтний лабораторийн судлаачид Монгол орны биологийн олон янз байдлын судалгаа хийсэн үр дүндээ суурилан тогтвортой ашиглалт ба хамгааллыг засгийн газарт зөвлөмж хүргүүлж ирсэн байна. Маш өндөр мэргэжлийн ур

чадвар, англи ба орос хэлний чөлөөтэй харилцаа нь Док. Б.Лхагвасүрэнг олон улсын судалгааны экспедицэд орох бололцоог бүрдүүлсэн. Тэрээр 100 гаруй шинжлэх ухааны өгүүллүүд хэвлүүлжээ.

Монгол улсын засгийн газар Док. Б.Лхагвасүрэнгийн ажил хөдөлмөрийг өндрөөр үнэлж 2015 оны шилдэг эрдэмтнээр шалгаруулсан ба Монгол улсын Байгаль орчны яамны зүгээс «Байгаль орчны тэргүүний ажилтан» цол тэмдгээр шагнасан бөгөөд түүнийг эх Монгол орныхоо төлөө бүхий л зүрх сэтгэл, ур чадвараа зориулан олон улсын

Гэгээн дурсгалд зориулав: үргэлжлэл

хэмжээний янз бүрийн түвшинд нийгэмлэг, комиссын гишүүдээр идэвхтэй амжилттай хамтран ажилладаг болохыг тэмдэглэжээ.

Док. Б.Лхагвасүрэнтэй хамтран ажиллаж байсан нэгэн болон түүнийг таньдаг хүн бүр түүний төлөв даруу зан чанар, Монгол орны зэрлэг амьтны хамгааллын төлөө өөрийгөө үл хайхран ажилладаг байсныг тэмдэглэн хэлдэг. Бөхөн хамгааллын холбооны гишүүд, бөхөн хамгааллын салбар бүрэлдэхүүнээрээ түүнийг дурсан санаж гэр бүлийнхэнд нь гүн эмгэнэл илэрхийлж байна. Түүний таалал төгссөн явдал нь дэлхийн байгаль хамгааллын салбарт урт удаан хугацааны нөхөгдөшгүй орон зайг үлдээлээ.

Анна Лушкина, Бөхөн хамгаалах холбоо

Цагаан зээрийн доктор

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын нийт хамт олон биологийн олон янз байдал ба байгаль хамгааллын дэлхийн хэмжээний судлаач Док. Б.Лхагвасүрэн

таалал төгссөнд гүнээ харамсаж байна. Тэрээр сүүлийн хэдэн 10 жилийн хугацаанд хүрээлэн буй орчны эрдэмтдийн дунд Монголын цагаан зээр, баавгай, хулан, хар сүүлт зээр болон бусад олон арван түлхүүр зүйлүүдийн хамгааллын чиглэлээр манлайлан ажиллаж ирсэн. Тийм ч учраас түүнийг цагаан зээрийн Лхагваа гэж нэрлэдэг.

Док. Б. Лхагвасүрэн 2010 оноос эхлэн Улаанбаатар дахь Дэлхийн байгаль хамгаалах санд /WWF/ Байгаль хамгааллын асуудал хариуцсан захирлаар ажиллаж эхэлсэн. Түүний хэмжээлшгүй их мэдлэг чадвар болон хуримтлуулсан туршлага нь манай байгууллагаас хэрэгжүүлж ирсэн бүх төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үнэлгээ, төлөвлөлт, хяналт мониторинг явуулахад гол үүрэг гүйцэтгэж ирсэн.

Энд ландшафт ба экологийн бүс нутгуудын стратеги төлөвлөгөөнүүдийг боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, ховор ховордож буй зүйлийн судалгаа, мониторинг, цэнгэг усны хамгаалал зэрэг нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэл



Док. Б.Лхагвасүрэн. Бөхөн хамгааллын Санамж бичигт гарын үсэг зурах уулзалтын үеэр яриа хийж байгаа нь. Улаанбаатар 2010 оны 9 сар. Зургийг: А. Эсипов

Гэгээн дурсгалд зориулав: үргэлжлэл

лээр шинжлэх ухаанд суурилсан байгаль хамгааллын олон арван компани ажлуудыг төлөвлөх хэрэгжүүлэх зэрэг ажлууд хамаарагдана.

Бид нар түүний бүтээсэн шинжлэх ухааны үндэстэй байгаль хамгааллын ажлуудын нэг тод жишээ болсон ажлыг дахин дурсмаар байна. Учир нь тэрээр Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газарт ажиллаж байхдаа Монгол орны хуурай газрын хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөнд дэд бүтцийн байгууламжуудаас үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох судалгаа шинжилгээний ажлын суурийг тавьж амжилттай эхлүүлсэн.

Энэ судалгаа нь 2025 онд тавигдах шинэ төмөр замын төлөвлөгөө гарснаар төмөр зам ба түүний хашаа, торноос хамааран Монгол орны цагаан зээрийн популяци 9 тусгаарлагдсан дэд хэсгүүдэд, хар сүүлт зээр 7 дэд популяци, харин хулан адууны хувьд 5 дэд популяци болж хуваагдах тухай дүгнэлт гаргажээ.

Түүнээс гадна Монгол бөхөнгийн популяци 2 тусгаарлагдаж тус тусдаа дэд популяци болох тухай дүгнэсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн

тэрээр Монгол улсын хэмжээнд анх удаа тал хээрийн зэрлэг амьтан, туруутны нүүдэл шилжилт хөдөлгөөнд зориулсан замын гарц гармын тухай стандартыг боловсруулан батлуулсан байдаг.

Лхагваа бол шилдэг биологич, хамтран ажиллаж байгаа хүмүүстээ нэр хүндтэй байнга хүндлэгдэж ирсэн нэгэн бөгөөд түүний таалал төгссөн нь байгаль хамгааллын салбарт үндэсний хэмжээнд ч олон улсын түвшинд ч том орон зай үлдээлээ. Түүний ажил үйлс дэлхийн хэмжээнд тоолшгүй олон хөгшин, залуу, хүүхэд, багачуудад байгалиа хайрлан хамгаалах итгэл төрүүлсэн. Док.Б.Лхагвасүрэн илүү гэрэл гэгээтэй өөдрөгөөр ирээдүйг харж байсан бөгөөд түүний хүсэл зорилго нь дэлхийгээ хадгалж, хамгаалан амьдрах явдал байлаа.

Док.Б.Лхагвасүрэн олон жилийн туршид бидний сайн анд нөхөр хамтран зүтгэгч байлаа, түүний сайхан инээмсэглэл, алиа хошин зан чанар болон олон сайхан түүх дурсамж бүрийг бид дурсан санаж байх болно.

Б. Чимэддорж, ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар

Талархал

Бид Бөхөн хамгаалах холбооны үйл ажиллагааг дэмжин цаг хугацаа болон мөнгөн хандив, хураамж өгч байдаг бүх хүмүүстээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бид энэхүү сониныг хэвлүүлэн гаргахад дэмжлэг үзүүлсэн Зэрлэг амьтан хамгааллын сүлжээ байгууллагад талархаж байна.



SAIGA CONSERVATION ALLIANCE

Бөхөн хамгаалах холбоо:

www.saiga-conservation.com

Бөхөнгийн нөөцийн төв:

www.saigaresourcecentre.com

Email: mail@saiga-conservation.com

©Saiga Conservation Alliance 2020 /
Registered charity England and Wales

© Андрей Гилев,
Карина Каренина